

**ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРООНЫ  
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА  
2025 оны 01 дүгээр сарын 10-ны өдөр, Баасан гараг**

**Хуралдааны тэмдэглэлийн агуулга**

**Хуралдааны товч тэмдэглэл:** 1-3

**Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:** 4-41

---

**1.Монгол Улсын Засгийн газар болон Монгол, Францын хамтарсан “Бадрах Энержи” ХХК-ийн хөрөнгө оруулагч Орано Майнинг С.А.С компани хооронд байгуулах Хөрөнгө оруулалтын гэрээний төсөл /Засгийн газар 2025.01.08-ны өдөр ирүүлсэн, зөвшилцөх, санал, дүгнэлтээ Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд хүргүүлнэ./** 4- 41

***Монгол Улсын Их Хурлын 2024 оны намрын ээлжит чуулганы  
Төсвийн байнгын хорооны 2025 оны 01 дүгээр сарын 10-ны өдөр  
/Баасан гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл***

Төсвийн байнгын хорооны дарга Ц.Даваасүрэн ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 25 гишүүнээс 13 гишүүн хүрэлцэн ирж, 52.0 хувийн ирцтэйгээр хуралдаан 11 цаг 51 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

*Томилолттой: Д.Батбаяр, Ж.Баясгалан;  
Чөлөөтэй: Н.Алтанхуяг, Б.Мөнхсоёл, П.Мөнхтулга, З.Мэндсайхан;  
Эмнэлгийн чөлөөтэй: Х.Болормаа, Б.Түвшин;  
Тасалсан: Ж.Ганбаатар.*

***Нэг.Монгол Улсын Засгийн газар болон Монгол, Францын хамтарсан  
“Бадрах Энержи” ХХК-ийн хөрөнгө оруулагч Орано Майнинг С.А.С компани  
хооронд байгуулах Хөрөнгө оруулалтын гэрээний төсөл /Засгийн газар  
2025.01.08-ны өдөр ирүүлсэн, зөвшилцөх, санал, дүгнэлтээ Аюулгүй байдал,  
гадаад бодлогын байнгын хороонд хүргүүлнэ./***

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Н.Учрал, Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Дэд дарга Д.Цолмон, Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга Б.Тэлмүүн, Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга Л.Энх-Амгалан, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Байгалийн нөөцийн бодлого зохицуулалтын газрын дарга Ц.Уранчимэг, мөн яамны Салбарын хяналтын газрын дарга Б.Мөнхтогтох, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Эрдэс баялгийн бодлогын газрын дарга Г.Намчинсүрэн, мөн яамны Хуулийн хэлтсийн дарга Т.Ганбаатар, Геологи, уул уурхайн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын ахлах шинжээч Ц.Өнөрнасан, Хуулийн хэлтсийн дарга Т.Ганбаатар, Усны газрын дарга З.Батбаяр, Татварын ерөнхий газрын Том татвар төлөгчийн газрын дарга С.Төгсжаргал, Мал эмнэлгийн ерөнхий газрын Мал, амьтны эрүүл мэндийн газрын дарга Б.Болдбаатар, Цөмийн энергийн комиссын ажлын албаны дарга Г.Манлайжав, мөн албаны Цөмийн аюулгүй байдлын бодлогын газрын дарга Э.Нямдаваа, Цөмийн технологийн бодлогын газрын дарга М.Чадраабал, Шинжлэх ухааны академийн Хими, химийн технологийн хүрээлэнгийн захирал Л.Жаргалсайхан, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын зөвлөх А.Мандуул, Б.Хулан, “Эрдэнэс Монгол” ХХК-ийн гүйцэтгэх захирал С.Наранцогт, мөн компанийн Дотоод хяналт, эрсдэлийн удирдлагын газрын дарга Л.Наранчимэг,

Хууль, эрх зүйн зөвлөлийн дарга Б.Гэрлээ, Геологи, үйлдвэрлэлийн бодлогын газрын дарга Ц.Төгсбуян, Хамтын ажиллагааны хэлтсийн менежер Т.Төрбадрах, “Мон Атом” ХХК-ийн гүйцэтгэх захирал Д.Далайжаргал, мөн компанийн Захиргаа удирдлагын албаны дарга Д.Сугарсүрэн, Уул уурхайн ахлах инженер А.Алтанхундага, “Эрдэнэс Оюутолгой” ХХК-ийн Геологи, уул уурхайн хэлтсийн ерөнхий менежер Л.Өнөрбаатар, Олон улсын харилцааны судлаач, профессор Д.Баярхүү, Физикийн ухааны доктор Н.Тэгшбаяр, Монголын мал эмнэлгүүдийн дундын хоршооны зөвлөх, академич Я.Ганболд, Дотоод хуулийн зөвлөх Г.Мөнхболд, Б.Батмандах, З.Шагдарсүрэн, С.Батхүлэг нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын ажлын албаны Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Ш.Хишигсүрэн, мөн албаны Төсвийн байнгын хорооны ажлын албаны референт Б.Мөнгөн-Аргамж нар байлцав.

Хөрөнгө оруулалтын гэрээний төслийн талаарх танилцуулгыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Н.Учрал танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Ж.Батжаргал, Г.Ганбаатар, Б.Заяабал, О.Номинчимэг, С.Ганбаатар нарын тавьсан асуултад Сангийн сайд Б.Жавхлан, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Н.Учрал, Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга Л.Энх-Амгалан, “Эрдэнэс Монгол” ХХК-ийн гүйцэтгэх захирал С.Наранцогт, Усны газрын дарга З.Батбаяр, Шинжлэх ухааны академийн Хими, химийн технологийн хүрээлэнгийн захирал Л.Жаргалсайхан, Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга Б.Тэлмүүн, Цөмийн энергийн комиссын ажлын албаны дарга Г.Манлайжав, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын зөвлөх Б.Хулан, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Эрдэс баялгийн бодлогын газрын дарга Г.Намчинсүрэн нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал, С.Ганбаатар, Ц.Даваасүрэн нар үг хэлэв.

**Ц.Даваасүрэн:** Монгол Улсын Засгийн газар болон Монгол, Францын хамтарсан “Бадрах Энержи” ХХК-ийн хөрөнгө оруулагч Орано Майнинг С.А.С компани хооронд байгуулах Хөрөнгө оруулалтын гэрээний төслийг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 11

Татгалзсан: 5

Бүгд: 16

68.8 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал, П.Ганзориг нарын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул санал хураалтын дүнг дэмжсэнээр хуралдааны тэмдэглэлд тэмдэглүүлэх санал гаргаж, дэмжсэнээр тооцов.

Нийт 16 гишүүнээс 13 гишүүн дэмжиж, 81.2 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны хуралдаанд танилцуулахаар тогтов.

*Уг асуудлыг 14 цаг 25 минутад хэлэлцэж дуусав.*

Байнгын хорооны хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

*Хуралдаан 2 цаг 34 минут үргэлжилж, 25 гишүүнээс 16 гишүүн хүрэлцэн ирж, 64.0 хувийн ирцтэйгээр 14 цаг 25 минутад өндөрлөв.*

**Тэмдэглэлтэй танилцсан:**

ТӨСВИЙН БАЙНГЫН  
ХОРООНЫ ДАРГА

Ц.ДАВААСҮРЭН

**Тэмдэглэл хөтөлсөн:**

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ  
ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

Д.ОТГОНДЭЛГЭР

## **МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ**

2025 оны 01 дүгээр сарын 10-ны өдөр,  
Баасан гараг  
Төрийн ордон “Жанжин Д.Сүхбаатар” танхим  
11 цаг 51 минут.

### **ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ**

**Ц.Даваасүрэн:** Хуралдаанд ирвэл зохих 25 гишүүнээс 13 гишүүн ирж, 52 хувийн ирцтэй байгаа учраас хуралдаанаа эхлүүлье. Бүртгүүлсэн гишүүд хуралдаандаа орж ирнэ үү.

Тилеуханы Аубакир, Батмөнхийн Батцэцэг гишүүн, Цэрэнпилийн Даваасүрэн гишүүн, Даваахүүгийн Пүрэвдаваа гишүүн, Баттогтохын Чойжилсүрэн гишүүн, Ринчиндоржийн Батболд гишүүн, Хүрэлбаатарын Булгантуяа гишүүн, Гонгорын Дамдинням гишүүн, Ганзоригийн Тэмүүлэн гишүүн, Жигжидийн Батжаргал гишүүн, Гомбын Ганбаатар гишүүн, Батжаргалын Заяабал гишүүн, Даваагийн Цогтбаатар гишүүн нар бүртгүүлсэн байна.

Бүртгүүлсэн гишүүд танхимд байхгүй байгаа гишүүд орж ирье. Хуралдаанаа явуулъя.

Ингээд Байнгын хорооны хуралдааны ирц 52 хувь байгаа учраас 25 оны 1 дүгээр сарын 10-ны өдрийн хуралдааныг нээснийг мэдэгдье.

Орж ирсэн, бүртгүүлсэн байгаа гишүүд ороод ирье. Ажлын хэсгийг бас дуудъя. Хуулийн төсөл танилцуулах ажлын хэсгийг дуудъя. Ажлын хэсгийн гишүүдийг би бас та бүхэнд танилцуулж байя. Өнөөдрийн хуралдаанаар хэлэлцэх асуудлыг би та бүхэнд танилцуулъя.

Монгол Улсын Засгийн газар болон Монгол, Францын хамтарсан “Бадрах Энержи” ХХК-ийн хөрөнгө оруулагч Орано Майнинг С.А.С компани хооронд байгуулах Хөрөнгө оруулалтын гэрээний төсөл хэлэлцэхээр байгаа.

Өнөөдрийн хэлэлцэх асуудалтай холбогдуулаад ажлын хэсгийг би та бүхэнд танилцуулъя.

Монгол Франц ураны төсөл, хөрөнгө оруулалтын гэрээний төслийн ажлын хэсэг Ням-Осорын Учрал, Монгол Улсын сайд Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга, Дорждэрэмийн Цолмон Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Дэд дарга, Лхагвабаярын Энх-Амгалан Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга, Бямбарагчаагийн Тэлмүүн Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга, Нармандахын Жамъянхүү Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын дарга, Гүнчинсүрэнгийн Намчинсүрэн Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Эрдэс баялгийн бодлогын газрын дарга, Цэрэндоржийн Уранчимэг Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Байгалийн нөөцийн бодлого зохицуулалтын газрын дарга, Баатарын Мөнхтогтох Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Салбарын хяналтын газрын

дарга, Баасансүрэнгийн Алимаа Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Нэгдсэн бодлого төлөвлөлтийн газрын дарга, Туулхангайн Ганбаатар Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Хуулийн хэлтсийн дарга, Зэнээмядарийн Батбаяр Усны газрын дарга, Сэрээндоржийн Төгсжаргал Татварын ерөнхий газрын Том татвар төлөгчийн газрын дарга, Бямбаагийн Болдбаатар Мал эмнэлгийн ерөнхий газрын Мал, амьтны эрүүл мэндийн газрын дарга, Гунаажавын Манлайжав Цөмийн энергийн комиссын ажлын албаны дарга, Энхгэрэлийн Нямдаваа Цөмийн энергийн комиссын ажлын албаны Цөмийн аюулгүй байдлын бодлогын газрын дарга, Маваагийн Чадраабал Цөмийн энергийн комиссын ажлын албаны Цөмийн технологийн бодлогын газрын дарга, Сэр-Одын Ган-Очир Ашигт малтмал, газрын тосны газрын Геологи ашиглалтын газрын дарга, Лхасүрэнгийн Жаргалсайхан Шинжлэх ухааны академийн Хими, химийн технологийн хүрээлэнгийн захирал, Бат-Эрдэнийн Хулан Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын зөвлөх, Алтангэрэлийн Мандуул Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын зөвлөх, Цагааны Өнөрнасан Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Геологи, уурхай бодлогын хэрэгжилтийн зохицуулах газрын ахлах шинжээч, Санжаагийн Наранцогт “Эрдэс Монгол” ХХК-ийн гүйцэтгэх захирал, Лувсаншаравын Наранчимэг. “Эрдэс Монгол” ХХК-ийн Дотоод хяналт, эрсдэлийн удирдлагын газрын дарга, Балжиннямын Гэрлээ “Эрдэнэс Монгол” ХХК-ийн нэгдлийн Хууль, эрх зүйн зөвлөлийн дарга, Цэдэнбалжирын Төгсбуян “Эрдэс Монгол” ХХК-ийн Геологи, үйлдвэрлэлийн бодлогын газрын дарга, Түмэнжаргалын Төрбадрах “Эрдэнэс Монгол” ХХК-ийн Хамтын ажиллагааны хэлтсийн менежер, Доржбалын Далайжаргал “Мон-Атом” ХХК-ийн захирал, Амарсайханы Алтанхундага “Мон-Атом” ХХК-ийн Уул уурхайн ахлах инженер, Дашдаваагийн Сугарсүрэн “Мон-Атом” ХХК-ийн Захиргаа удирдлагын албаны дарга Лхагвын Өнөрбаатар, “Эрдэнэс Оюутолгой” ХХК-ийн Геологи, уул уурхайн хэлтсийн ерөнхий менежер, Батцэнгэлийн Баяр-Өлзий “Эрдэнэс Оюутолгой” ХХК-ийн Санхүү, шинжилгээний хэлтсийн ерөнхий менежер, Цэрэндоржийн Мөнх-Оюунбаатар “Эрдэс Монгол” ХХК-ийн Хуулийн хэлтсийн ахлах мэргэжилтэн, Дашдоржийн Баярхүү Олон улсын харилцааны судлаач, профессор, Яндагийн Ганболд Монголын мал эмнэлгүүдийн дундын хоршооны зөвлөх, Монгол Улсын шинжлэх ухааны гавьяат зүтгэлтэн, академич, профессор, Норовын Тэгшбаяр Физикийн ухааны доктор, Ганбатын Мөнхболд Дотоодын хуулийн зөвлөх, Баярбатын Батмандах Дотоодын хуулийн зөвлөх, Зуунайн Шагдарсүрэн Дотоодын хуулийн зөвлөх, Сүхдоржийн Батбилиг Дотоодын хуулийн зөвлөх гэсэн ийм ажлын хэсгийн бүрэлдэхүүн оролцож байгаа юм байна. Тэгээд ажлын хэсгийг оруулъя. Ажлын хэсгээ дуудъя. Манай хуралдаан эхэлж байна гээд хэлчих.

Бүртгүүлсэн гишүүд орж ирье. Аубакир гишүүн, Батцэцэг гишүүн, Пүрэвдаваа гишүүн, Батболд гишүүн, Булгантуяа гишүүн, Дамдинням гишүүн, Тэмүүлэн гишүүн, Батжаргал гишүүн, Ганбаатар гишүүн, Гомбын Ганбаатар гишүүн, Даваагийн Цогтбаатар гишүүн нар орж ирье.

Гишүүдээ дуудъя. Аубакир гишүүн, Батцэцэг гишүүн, Пүрэвдаваа гишүүн, Батболд гишүүн, Булгантуяа гишүүн, Дамдинням, Тэмүүлэн гишүүн, Батжаргал гишүүн, Гомбын Ганбаатар гишүүн, Даваагийн Цогтбаатар гишүүн нарыг дуудъя. Хуралдаанаа үргэлжлүүлье.

Та бүхэнд би өнөөдөр хэлэлцэх асуудлыг танилцуулъя. Тэгээд ажлын хэсгийн нь хооронд дуудъя.

Өнөөдрийн хуралдаанаар Монгол Улсын Засгийн газар болон Монгол, Францын хамтарсан “Бадрах Энержи” ХХК-ийн хөрөнгө оруулагч Орано Майнинг компани хооронд байгуулах Хөрөнгө оруулалтын гэрээний төсөл байгаа. Энэ асуудлыг хэлэлцэнэ.

Хэлэлцэх асуудлаар саналтай гишүүн байна уу?

Хэлэлцэх асуудалтай холбогдоод саналтай гишүүн алга байна.

Хэлэлцэх асуудлын танилцуулгыг, айн үдээс хойш уу? Учрал сайдыг оруулъя. Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг би танилцуулчихсан байгаа. Одоо хөрөнгө оруулалтын гэрээний төслийн талаарх танилцуулгыг Монгол Улсын сайд Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Ням-Осорын Учрал танилцуулъя. Учрал сайдыг дуудъя.

Хөө нөгөө ажлын хэсэг яасан бэ? Ажлын хэсгээ оруулж ирээд танилцуулга хийлгэ. Гишүүд хүлээе. Айн? Яагаад давхардуулж зарласан юм бол? Тэгээд давхардуулж зарлачхаад ажлын хэсэг байхгүй байна гээд гишүүдийг хүлээлгээд суулгаад байх юм. Юу ч гэсэн манайхан хэлчих Байнгын хорооны хурал эхэлчихсэн байна, орж ирж асуудлаа танилцуул гээд.

Учрал орж ирж танилцуулна. Тийм, тэгээд давхар зарлачихсан байгаа байхгүй юу. Тийм, Хөдөө аж ахуй бас хүлээж байгаа. Ингээд бүгдийг нь давхардуулчихсан. Тэгээд гишүүд ирээд хүлээгээд суугаад байгаа. Хэлье манайхан хэлчих Байнгын хорооны гишүүд ирчихсэн ингээд хүлээгээд суугаад байна, асуудлаа танилцуулъя гээд.

Ажлын хэсэг орж ирлээ. Учрал сайд танилцуулга хийе. 5 номерын микрофон.

**Н.Учрал:** Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газар болон Бүгд Найрамдах Франц Улсын Орано Майнинг компанийн хооронд байгуулах уран олборлох төслийн хөрөнгө оруулалтын гэрээний төслийг Монгол Улсын эрх ашиг хууль тогтоомжид нийцүүлж, хөрөнгө оруулагч талтай урьдчилан тохирч боловсруулж, Цөмийн энергийн хуулийн 30.3-д заасны дагуу зөвшилцөхөөр танилцуулж байна.

Зөвч Овоо, Дулаан уулын ураны ордыг эдийн засгийн эргэлтэд оруулах энэхүү төсөл нь хамтарсан Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн улсын хөгжлийн бүтээн байгуулалтын 14 мега төслийн нэг бөгөөд энэхүү гэрээг хэрэгжүүлснээр гадаадын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлж, улс, орон нутгийн төсөвт хөрөнгө төвлөрүүлэх, ажлын байрыг бий болгох, шинэ технологи нутагшуулах, мөн олон улсын хамтын ажиллагаа зэрэг нийгэм, эдийн засагт үзүүлэх шууд нөлөөллөөс гадна цаашид уур уурхай ашигт малтмалын салбарт хийгдэх хөрөнгө оруулалтын гэрээнд жишиг тогтоох үр дагавартай.

Хөрөнгө оруулагч нь Монгол Улсад 1997 оноос хойш хайгуул олборлолтын чиглэлээр тасралтгүй 27 жил үйл ажиллагаагаа явуулж байгаа бөгөөд 2021 оны 7 дугаар сараас Зөвч Овоо ордын үйлдвэрлэлийн туршилтын ажлыг эхлүүлж, 2022 оны 12 дугаар сард амжилттай гүйцэтгэж дуусгасан.

2023 оны 5 дугаар сараас эхлэн Монгол Улсын Ерөнхий сайдын хэд хэдэн захирамжаар хөрөнгө оруулалтын гэрээний төслийн хэлэлцээг хийж, эцэслэн боловсруулсан хувилбарыг Засгийн газрын хуралдаанд танилцуулах үүрэг бүхий ажлын хэсгүүд, тус ажлын хэсэгт дэмжлэг үзүүлэх мэргэжлийн байгууллага, эрдэмтэн судлаачид, хөндлөнгийн төлөөлөл бүхий өргөн бүрэлдэхүүнтэй ажлын дэд хэсгүүд, гэрээ, эрх зүй, эдийн засаг, хөрөнгө оруулалт, татвар, санхүү, олборлолт, үйлдвэр технологи, байгаль орчин, орон нутгийн чиглэл гэсэн 5 чиглэлд ажлын дэд хэсгүүд байгуулагдаж, гэрээний хэлэлцээг үргэлжлүүлэн хийж, эцэслэсэн хувилбарыг боловсруулан ажиллалаа.

Ажлын хэсгээс гэрээний төслийн хувилбарыг боловсруулахдаа Монгол Улсын эрх ашигт нийцсэн стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордыг ашиглахдаа дийлэнх үр өгөөж ард түмэнд ноогдож байх, талуудын хүртэх өгөөжийг тэнцвэртэй хангах суурь зарчмуудыг хатуу баримталж, ирээдүйд аливаа эрх зүйн үр дагаваргүй хэрэгжих боломжийг бүрдүүлэх, цаашид жишиг гэрээ болох нөхцөлийг хангахад анхаарсан болно.

Мөн энэ чиглэлээр олон улсад нэр хүнд бүхий мэргэшсэн санхүү, хууль, байгаль орчны зөвлөхүүд болон дотоодын зөвлөхүүдтэй хамтран ажилласныг цохон тэмдэглэх нь зүйтэй.

Монгол Улсын Засгийн газраас Монгол Улсын хууль тогтоомж, олон улсын эрх зүйн зарчмыг баримтлан хөрөнгө оруулагчтай нийт 18 удаагийн хэлэлцээг хийж, Монгол Улсын эрх ашиг, Монгол Улсын Үндсэн хуулийн суурь зарчимд нийцүүлэн боловсрууллаа.

Эдийн засгийн хөгжлийн сайдаар ахлуулсан ажлын дэд хэсэг ажиллаж, эдийн засаг, хөрөнгө оруулалтын чиглэлээр дараах нөхцөлүүдийг урьдчилан тохироод байна. Үүнд:

Анхны хөрөнгө оруулалтын хэмжээ нь ойролцоогоор 500 сая ам.доллар байх бөгөөд гэрээ хүчин төгөлдөр болох өдрөөс хойш 4 жилийн хугацаанд хийхээр тусгаж, хөрөнгө оруулагчийн хүлээх үүрэг, хариуцлагыг тодорхой хугацаатай зааж өглөө.

Анхны хөрөнгө оруулалтын хувьд төслийн хөрөнгө оруулалт, үйл ажиллагааны санхүүжилтийг зээл, түүнтэй адилгаж санхүүгийн хэрэгслээр бүрдүүлэхгүй өөрийн хөрөнгөөр санхүүжүүлэхээр тохирсон ба төслийн хугацаанд хувь нийлүүлэгчийн зээлийг зөвшөөрөхгүй ба зээл авах зайлшгүй шаардлага үүссэн тохиолдолд хувьцаа эмшигчийн хурлын шийдвэрээр шийдвэрлэхээр тохирлоо.

Гэрээ хүчин төгөлдөр болох өдрөөс өмнө төсөл хэрэгжүүлэгч компанид олгосон хувьцаа эзэмшигчийн зээлийг төсөл хэрэгжүүлэгч компанийн хувь нийлүүлсэн хөрөнгөд шилжүүлэхээр тохирлоо.

Хөрөнгө оруулагч талаас ирүүлсэн санхүүгийн тооцооллын шууд ашиглахаас илүүтэйгээр ТЭЗҮ-д тулгуурлан олон улсын фаст стандартын дагуу өөрийн талын санхүүгийн тооцооллын загварыг Монголын тал боловсруулж, хөрөнгө оруулагчдаа тулган баталгаажуулалт хийсний үндсэн дээр стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын үр өгөөжийн дийлэнх хэсэг буюу 51-ээс



доошгүй хувийг Монгол Улс хуримтлагдсан дүнгээр жил бүр хүртэх нөхцөлийг баталгаажууллаа.

Гэрээний төсөлд Засгийн газар болон хөрөнгө оруулагч талд ноогдох үр өгөөжид тооцох орлогыг тусгайлан дурдаж, хэрэв Монголын талын хувьд шууд өргөөж 51 хувьд хүрэхгүй тохиолдолд хөрөнгө оруулагч болон төсөл хэрэгжүүлэгч компани нь үр өгөөжийг 51 хувьд хүргэх шаардлагатай үр өгөөж тохируулах нэмэлт төлбөрийг Засгийн газарт нөхөн төлөх үүрэгтэй байхаар тохиролцлоо.

Засгийн газар, төсөл хэрэгжүүлэгч компанийн эздийн өмчийн 10 хувьтай тэнцэх төрийн эзэмшлийн давуу эрхийн хувьцааг үнэ төлбөргүй шууд эзэмших ба хувь, хэмжээг бууруулахгүй байхаар тохирлоо.

Засгийн газар нь бүтээгдэхүүний 10 хүртэлх хувийг хөрөнгө оруулагчтай ижил нөхцөл, болзлын дагуу худалдан авахаар гэрээний төсөлд тусгалаа.

Засгийн газар нь компанийн дүрэмд өөрчлөлт орох, тусгай зөвшөөрлийг шилжүүлэх, барьцаалах, баталгаа гаргах болон хөрөнгө оруулалтын болон үйл ажиллагааны зардалд нэмэлт оруулах асуудлаар хориг тавих эрхтэй байх заалтыг тусгалаа.

Татвар, санхүүгийн чиглэлээр дараах асуудлуудыг тохиролцлоо.

Нэгд, Хөрөнгө оруулагч талаас нийт 27 төрлийн татварыг тогтворжуулах саналыг ирүүлснийг хэлэлцээрийн явцад бууруулж зөвхөн Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар, нэмэгдсэн өртгийн албан татвар, ашигт матмалын нөөц ашигласны төлбөр, гаалийн тариф гэсэн 4 төрлийн татварыг тогтворжуулахаар тохирлоо.

Татвар тооцох аргачлалыг өргөн утгаар нь тогтворжуулах саналыг ирүүлснийг хэлэлцэж, зөвхөн татварын төрөл, хувь хэмжээ, элэгдэл, хорогдолд тооцох хугацаа, алдагдал, ирээдүйд шилжин тооцох хугацаа гэсэн 3 үзүүлэлтийг тогтворжуулахаар тохирлоо.

Ашигт матмалын нөөц ашигласны төлбөрийг үндсэн болон нэмэгдүүлсэн хувиар тооцох бөгөөд тусгай төлбөрийг бүтээгдэхүүний борлуулалтын үнэлгээнээс хасагдуулах инфляц тооцохгүйгээр бүрэн төлөхөөр тусгалаа.

Татварын суурийг багасгах, ашиг шилжүүлэхийн BEPS-ийн эсрэг зарчим болон Дотоодын хуулийг бүрэн дагаж мөрдөхөөр гэрээний төсөлд тусгалаа.

Маркетингийн төлбөрийг татварын болон санхүүгийн тайлангийн зорилгоор хасагдах зардалд зардлаар бүртгэхгүй болохыг хэлэлцээрийн явцад хөрөнгө оруулагч талаар зөвшөөрүүлж чадлаа.

Засгийн газрын 2010 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн 286 дугаар тогтоолоос хойш өнөөг хүртэл шар нунтгийг ашигт малтмалын эцсийн бүтээгдэхүүнд тооцож, экспортод “тэг” хувийн нэмэгдсэн өртгийн албан татвар ноогдуулан буцаан олгохоор заасныг өөрчлөхөөр хатуу байр суурийг баримтлан хэлэлцээрийг хийлээ.

Хөрөнгө оруулагч талаас зөвхөн ураны төсөлд зориулж тогтоол өөрчлөхийг зөвшөөрөх боломжгүй гэсэн байр суурийг илэрхийлж байсан юм.

Улмаар хэлэлцээрийн явцад Засгийн газар эцсийн бүтээгдэхүүнд “тэг” хувийн НӨАТ ноогдуулах асуудлаар нэгдсэн бодлогоор бүх уул уурхайн компанид ижил хандсан тохиолдолд НӨАТ төлөхийг зөвшөөрөх боломжтой талаар хөрөнгө оруулагч талтай харилцан ойлголцолд хүрч, гэрээний төсөлд тусгалаа.

Энэхүү хөрөнгө оруулалтын гэрээг байгуулж хэрэгжүүлснээр улс, орон нутгийн төсөвт жилд 520 тэрбум, төслийн нийт хугацаанд 17.1 их наяд төгрөг, Үндэсний баялгийн санд жилд 61.5 тэрбум төгрөг, төслийн нийт хугацаанд 2 их наяд төгрөгийг төвлөрүүлж, 1600 орчим шинэ ажлын байрыг бий болгож, шинэ технологи нутагшуулж, хүхрийн хүчлийн үйлдвэр зэрэг бүтээн байгуулалт хийгдэх боломж бүрдэх болно.

Энэхүү ураны ордыг ашиглах хөрөнгө оруулалтын гэрээ байгуулагдсанаар гадаадын хөрөнгө оруулалт нэмэгдэж, шинэ төрлийн үйлдвэрийг хөгжүүлэх, төсвийн орлого, ДНБ-ий өсөлт, ажлын байрыг нэмэгдүүлж, дэвшилтэт технологи, мэдлэгийг, туршлагыг нэвтрүүлж, мэргэшсэн боловсон хүчний нөөц бүрдүүлэх зэрэг нийгэм, эдийн засгийн үр өгөөжийг бий болгохоос гадна Монгол Улс стратегийн ач холбогдол бүхий бүтээгдэхүүн экспортлогч орон болж, улмаар ураны зах зээлийн гол тоглогчдын болох нүүрсхүчлийн хий ялгаруулдаггүй цэвэр эрчим хүчний эх үүсвэрийг хөгжүүлэх эхлэл тавигдах болно.

Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газар болон Орано Майнинг компанийн хооронд байгуулах хөрөнгө оруулалтын гэрээний төслийг зөвшилцөхөөр та бүхэнд танилцуулж байна.

Хэлэлцэн дэмжиж өгөхийг хүсье. Баярлалаа.

**Ц.Даваасүрэн:** Учрал сайд баярлалаа.

Хөрөнгө оруулалтын гэрээний төсөлтэй, танилцуулгатай холбогдуулаад асуух асуулттай гишүүдийн нэрсийг авъя.

Булгантуяа гишүүнээр тасалъя. Батжаргал гишүүн асуултаа асууя.

**Ж.Батжаргал:** Баярлалаа. Тэгэхээр энэ хөрөнгө оруулалтын гэрээний төсөлтэй танилцсан бид хэд тэр Үндсэн хуулийн 6.2-ын баялгийн өгөөжийн дийлэнх хэсэг ард түмэнд оногдох ёстой гэдэг энэ зарчмыг баримталж, гэрээний боловсруулалтыг нэлээн анхаарч хийсэн юм билээ гэж ингэж харагдаад байгаа.

Гэхдээ хуулиар тусгайлан зохицуулчихсан асуудлууд байгаад байгаа юм. Энэ стратегийн ач холбогдол бүхий ордын 34 хувийг төр үнэ төлбөргүй эзэмших тухай асуудал байгаад байгаа. Үүнийгээ биднүүс 10-ыг нь тэр давуу эрхийн хувьцаагаар орлуулж байгаа юм байна гэж ингэж харагдаж байгаа. Үлдэж байгаа хэсгийгээ ашигт матмалын нөөц ашигласны төлбөрөөр тусгай төлбөрөөр орлуулахаар ингэж хуульчлагдсан. Тэгээд энэ гэрээн дотор ингээд уншаад үзэхээр зэрэг энгийн 34-ийг давуу эрхийн 10-т шилжүүлсэн тухай л асуудал байгаад байгаа юм. Тэр цаад үлдэж байгаа хэсгийг ашигт малтмалын нөөц ашигласны тусгай

төлбөрөөр орлуулах тухай ч 1 үг байхгүй байгаад байгаа. Үүн дээр юу гэж хэдүүлээ ойлгох вэ гэдэг ийм асуудал байгаад байдаг.

Хоёр дахь зүйл. Угаасаа бид Үндэсний баялгийн сангийн хуулиараа тэр төрд ноогдож байгаа 34 хувьд ноогдох ашиг ашигт Үндэсний баялгийн сангийн хуримтлалын санд орох ёстой. Тэр мөнгө өөрөө иргэн бүрийнхээ нэр дээр, нэрийн дансанд байрших ёстой. Буцаагаад бид боловсрол, эрүүл мэнд, орон сууцад нь чиглүүлэхээр ингэж зааж өгсөн.

Тийм учраас энэ үндсэндээ баялгийн эзэд ард түмэнд шууд хуваарилагдаж очих ёстой мөнгө болж ингэж харагдаж байгаа юм.

Гэтэл үүний талаар энэ гэрээн дотор тийм тодорхой ойлголт юмнууд харагдаж өгөхгүй байгаа. Өчигдөр Их Хурал дээр яригдсан орлуулах тухай Их Хурлын тогтоол дотор хавсралтаар бид ашигт матмалын нөөц ашигласны төлбөрийн тусгай төлбөрийг 5 хувь байхаар ингээд заагаад өгчихсэн. Одоо эндээс бид наад хөрөнгө оруулалтын гэрээ хийгдэж байгаа өнөө ордуудын ТЭЗҮ бидэнд хэрэгтэй болчихоод байна. Тэр ТЭЗҮ яг батлагдсан уу? Батлагдаагүй юм аа гэхэд нийт борлуулалтын чинь мөнгөн дүн хэд вэ? Татварын дараах цэвэр ашиг нь.../минут дуусав./

**Ц.Даваасүрэн:** 5 номерын микрофон хариулъя. Учрал сайд.

**Н.Учрал:** Тийм, манай хуулиар, Ашигт малтмалын хуулиар, сая 4 сард батлагдсан Үндэсний баялгийн сангийн хуулиар яг Батжаргал гишүүний хэлж байгаа стратегийн ордуудынхаа 34, хэрвээ улсын төсвөөр нөөцийг нь тогтоосон бол 50 хувийг нь үнэ төлбөргүйгээр эзэмших хуультай. Энэ хүрээндээ энэ Францтай хамтарч байгаа энэ төслийн хүрээнд хамтарсан компани байгуулаад 34 хувийг нь Монгол талын компани эзэмшдэг байсан. Ингээд Монгол Улсын Ерөнхийлөгчийн Франц Улсад айлчлах үеэр энэ хэлэлцээ хийгдээд, хэлэлцээний протоколд гарын үсэг зурагдсан. Тухайн үед манай Ашигт малтмалын хууль дээр төрийн эзэмшлийн хувь, хэмжээг АМНАТ-аар орлуулах, бүтээгдэхүүн хуваахаар орлуулах боломжийг нь хуулиар нээчихсэн байдаг.

Ингээд түүнийг орлуулах нь ашигтай юм байна. Үгүй болохоор ерөөсөө энэ ноогдол ашиг нь хугацаа нь хойшлоод энэ Оюу толгой шиг юм үүснэ гэдэг ийм болгоомжлол байсан учраас орлуулах нь зөв гэдэг зарчмын хүрээнд тухайн үед Амарбаясгалан даргаар ахлуулсан энэ ажлын хэсгийг шийдвэрлээд, өмнө нь Нямбаатар сайдын үед энэ асуудлыг зарчмын хувьд хэлэлцээгээр тохироод Амарбаясгалан даргын үед энэ гэрээ зурагдсан. Тэгээд 10 хувь, тэгээд АМНАТ-аар орлуулъя гээд. Тухайн үед Ашигт малтмалын хуулиар тусгай АМНАТ-ын дээд босго 5 хувь байсан. Одоо бид нар сая босгыг байхгүй болголоо шүү дээ.

Тэгээд тусгай АМНАТ-ын 5 хувь байхад орлуулаад яаж 50 дээр тэр 51-ээ хангуулах вэ гээд зарчмаа тавьсан чинь ямар боломж үүссэн бэ гэхээр өсөн нэмэгдэх АМНАТ-ыг тохирох бололцоо үүссэн. Өсөн нэмэгдэх АМНАТ нь 0-9 буюу ураны зах зээлийн үнэ ингэж савлагаатай, дандаа ийм эрэлт нь өсөх бололцоотой байгаа үе гэж тохиолдуулаад бид нар тэр өсөн нэмэгдэх АМНАТ-ыг тооцуулах чиглэлээр хэлэлцээ хийсэн.

Ингээд Их Хурлын тогтоолоор зөвхөн 3 тусгай зөвшөөрлийн хүрээнд үйл ажиллагаа явуулах энэ компанийн төрийн эзэмшлийн 34 хувийг давуу эрхийн 10

буюу санхүүгийн ямар ч хариуцлага хүлээхгүй, хөрөнгө оруулалт хийхгүй, тэгээд давуу эрхийн хувьцаатай хориг тавих вето эрхтэй ТУЗ-ийн төлөөлөлтэйгөөр шийдвэрлээд, тусгай АМНАТ-ын 5, өсөн нэмэгдэх АМНАТ, дээрээс нь 13 янзын төлбөр, татвар, хураамжийг тооцоод үзэхээр Үндсэн хуулийн суурь зарчим 6.2-ыг хангуулаад 51-ээс дээш үр өгөөжийг Монголын Засгийн газар хүртэх юм байна. Тэгээд үүнээсээ Үндэсний баялгийн сангийн хууль өнөөдөр эцсийн хэлэлцүүлэг хийгдлээ. Энэ хуулиараа тусгай АМНАТ-аар орлуулсан бол тэр орлуулсан үр өгөөж нь шууд хуримтлалын данс буюу иргэдийн хуримтлалын данс руу шилжүүлдэг болгоод ингээд зохицуулчихлаа.

Тэгэхээр бид бол энэ төслөөс борлуулалтаас нь АМНАТ авах учраас нөгөө эрсдэл багатай гэж байгаа юм. Хэрвээ тэр эзэмшлийн 34 хувиа ноогдол ашгаа өгнө гээд өөдрөгөөр төсөөлөх юм бол эрсдэл нь 18 хувьтай, юу 45 хувьтай. Ингээд эрсдэл нь хэрвээ орлуулаад явчих юм бол 18 хувьтай гээд багасах юм байна. Эрсдэл багатай орлого байх юм байна гэж ингээд үзсэн.

Тэгэхээр төрийн эзэмшлийн 34-ийг үнэгүй аваад, түүнийгээ Их Хурлын тогтоолоор орлуулж болох эсэх нь Их Хурлын онцгой бүрэн эрхэд хадгалагддаг учраас тэр эндээс, энэ төслөөс жишээ нь 34-өө ч юм уу, 50-иа ч юм уу бүрэн татгалзаад байгаа биш Их Хурлын энэ шийдвэрээр төсөл хэрэгжих хугацаанд тодорхой хувиа, үр өгөөжөө хүртэхдээ АМНАТ-аар, давуу эрхийн хувьцаагаар, өсөн нэмэгдэх АМНАТ-аар 13 янзын төлбөр, татвараар орлуулж чадвал 51-ээ хангах юм байна гэдэг санхүүгийн өөрсдийн схемээ гаргаад л шийдвэрлээд л яг нөгөө санхүүгийн моделийнх нь дагуу явж байгаа. Бид нарын боловсруулсан санхүүгийн модель бол ийм динамик. Тэрнээс биш дэлхийн зах зээл дээр юу ч болоо билээ үүнийг тооцож чадахгүй. Тэгээд динамик байдлаар хийсэн учраас ийм тохируулгаа өөрсдөө хийгээд л явна. 51 хүрэхгүй бол өгөөжөө тохируулна. Тэгэхээр Монголын Засгийн газарт ашигтай л ийм л хувилбар гэж үзэж байгаа юм.

**Ц.Даваасүрэн:** Батжаргал гишүүн тодруулъя.

**Ж.Батжаргал:** Тэгээд бид бусад татвар төлбөрүүдээрээ 51-ээ давуулах ийм бодлого бариад байгаа юм. Гэтэл наад Цөмийн энергийн тухай хууль, одоо бид нарын нэмэлт оруулж байгаа Ашигт малтмалын тухай хууль эд нарт чинь төрийн эзэмшлийн 34-ийг ашигт малтмалын нөөц ашигласны зөвхөн тусгай төлбөрөөр орлуулж болохоор заасан байхгүй юу.

Тэгэхээр тэр 34 чинь давуу эрхийн 10, тэр тусгай төлбөрийн нийлбэр дүнгээр л балансжих ёстой. Тэгэхээр энэ болохгүй болчхоод байгаа байхгүй юу. Одоо бид нарын Үндэсний баялгийн сангийн тухай хуульдаа оруулж байгаа нэмэлт, өөрчлөлтүүд талаасаа ч харсан наад 34 хувь чинь баригдаж өгөхгүй байгаад байгаа. 10-ын давуу эрхээр авагдчихаад тэгээд 5 хувийн АМНАТ авахаар зэрэг урьдчилсан байдлаар, томсгосон тооцоог нь харахаар зэрэг бараг 2 дахин бага тооцоолол харагдаад болж өгөхгүй байгаа байхгүй юу. Нийт борлуулалтын орлогоо бид 15.../минут дуусав./

**Ц.Даваасүрэн:** Хариулъя. Энэ чинь 50 доллар хүртэл “тэг” байгаа шүү дээ. Тэрийгээ та бас сайн тайлбарлаж хэлээрэй. Тэгэхгүй бол авч чадахгүй болчихно шүү дээ. 50 доллароос дээш болж байж авч эхэлж байгаа шүү дээ.

5 номерын микрофон.

**Н.Учрал:** Яах вэ Батжаргал гишүүн ээ ийм л юм л даа төр үнэ төлбөргүйгээр Үндэсний баялгийн сангийн хуулийн дагуу стратегийн ордуудыг эзэмшдэг. 34, 50. Ингээд уран болоод Цөмийн энергийн хуулиараа өөрөө стратегийн бүтээгдэхүүнд тооцогддог. Тэгэхээр 34 хувьтай. Энд Их Хуралд ямар бүрэн эрх байгаа вэ гэхээр тэр Үндсэн хуулийн 6.2-ыг хангуулахад 34-өө ямар хэлбэрээр орлуулах вэ гэдгээ Их Хурал шийдээд, эцсийн үр дүнд 51 л байх ёстой байхгүй юу. Ийм хуулийн эрх байгаа байхгүй юу энийг орлуулах. Тэгэхдээ та жишээ нь давуу эрхийн 10, 24 хувь дээр тусгай АМНАТ-ын 5, тэгээд өсөн нэмэгдэх 0-9 гэхээр тэр шууд утгаараа хүрэхгүй байна гэж ярьж болохгүй л дээ. Яагаад гэхээр энэ чинь та ингээд, би таны ярианаас болохоор нөгөө шууд 34 хувийн АМНАТ ав гэж хэлээд байна гэж ойлгоод байна шүү дээ. Тийм юм байхгүй шүү дээ борлуулалтаас нь.

Яагаад гэхээр АМНАТ гэдэг борлуулалтаас авч байгаа. Тэр чинь 2 талдаа ашигтай байх ёстой шүү дээ. Тэгэхгүй бол Монголд хэн хөрөнгө оруулах юм. Дэлхийд байхгүй ийм өндөр АМНАТ тооцчихоод байгаа юм л даа.

**Ц.Даваасүрэн:** Үгүй ээ, уран дээр хөрөнгө оруулалт татна гэдэг ойлголт байдаггүй юм Учрал аа. Алт, уран, зэс дээр. Тэд гуйдаг байхгүй юу. Тийм учраас битгий та нар тэгж ярьж бай. Энэ чинь стратегийн бүтээгдэхүүн. Дэлхий гуйж байгаа бүтээгдэхүүн байхгүй юу.

Батжаргал гишүүн дутуу хариулсан учраас тодруулъя гэж байна.

**Ж.Батжаргал:** Үгүй ээ, уул нь ингээд ярихаар ойлгогдмоор л юм яриад байгаа юм. Борлуулалтын орлогоосоо АМНАТ авна бид хэд. Мөн үү ашигт матмалын нөөц ашигласны төлбөр? Хэрвээ бид 34 хувьдаа ноогдол ашиг авна гэвэл цэвэр ашгаасаа авах болно. Тэгэхээр наад ТЭЗҮ-ээр чинь борлуулалтын орлогоо хэд гэж тооцоод байгаа юм бэ? Цэвэр ашгаа хэд гэж тооцоод байгаа юм бэ? Тэгэхээр цэвэр ашгаас 34 хувь ноогдох тооцоолсон мөнгөн дүн чинь бидэнд хэрэгтэй байгаад байна шүү дээ. Тэрнийх нь 10 хувийг давуу эрхийн хувьцаагаар авч болж байна. Цаад 24-д хэдэн төгрөг ноогдоод байгаа юм. Тэрүүнийгээ бид наад борлуулалтын орлоготойгоо харьцуулж байж 5 юм уу, 8 юм уу гэдэг наад тусгай АМНАТ-ын тусгай төлбөрийн хувь чинь гарах гээд байгаа байхгүй юу. Одоогийн тооцож байгаа тооцооллоороо би өөрөө энэ яваад байгаа материал дээр чинь тулгуурлаад харахаар зэрэг.../минут дуусав./

**Ц.Даваасүрэн:** Тэр нэлээн тооцоо хийсэн. Одоо хар аа энэ 34-өөс чинь 10-ыг нь яачихаас цаана нь 24-өө яаж тооцож байгаа юм бэ гээд байна шүү дээ. Тэрийг нь та нар сайн хариул л даа. Тэгээд 50 доллароос дээш өсөж байж л авна шүү дээ. 50 доллароос доош байгаад байгаа юм бол авахгүй шүү дээ бас. Тэгээд юмыг бас нийгэмд бодитой үнэнээр нь ярь л даа та нар. 7 номер.

**Л.Энх-Амгалан:** Эдийн засаг, хөгжлийн яам Энх-Амгалан.

Энэ төслийн хувьд ТЭЗҮ дээр, санхүүгийн тооцоолол дээр ураны үнийг фунтийн 80 доллароор тооцож байгаа. Ингээд тооцоход төслийн нийт хугацаанд нийт борлуулалтын орлого нь 14 тэрбум доллар болно. Үүнээс татвар зарлалын дараа цэвэр ашиг нь 5.5 тэрбум доллар болно. 5.5 тэрбум доллароос ноогдол ашиг хуваарилах тухай асуудал яригдана тээ.

Нөгөө талдаа тусгай АМНАТ 700 гаран сая доллар болж байгаа юм.

Манай ноогдол ашгаар авах дүн бол 600-гаад сая доллар болно. 500 гаруй сая доллар. Ингээд энэ багцаагаар 1.2-1.3 тэрбум долларын асуудал байгаа манайх авч байгаа нь.

Гэтэл цэвэр ашгийн 5.5 тэрбум доллараас компани хэдэн хувийг нь ноогдол ашгаар тараах вэ гэдэг асуудал яригдана.../минут дуусав./

**Ц.Даваасүрэн:** 7 номерын микрофоныг сунгаад өгчихье. Гүйцэж гүйцээж хариулъя.

**Л.Энх-Амгалан:** Ноогдол ашиг хуваарилах дээр нийтлэг практик бол 40-50 хувийг нь л жилдээ хуваарилж байгаа юм. Тэгэхээр ноогдол ашиг хуваарилах боломжтой дүн магадгүй 2.5 тэрбум доллар болж байгаа юм. Тэгэхээр энэний 34 хувь руу дүйцүүлж ойлговол энэ найм, есөн зуун тэрбум доллар хүрэхгүй ийм үнэлгээ л болж байгаа юм.

Тэгэхээр дүйцүүлж ойлгохын тухайд том тоонуудыг ингэж дүйцүүлж ойлговол илүү зохимжтой байгаа юм. Тэрнээс биш шууд борлуулалтын орлогоос 34 хувь, эсвэл шууд нийт ашгаас 34 хувь гээд ингээд ойлговол энэ дараа нь амьдрал дээр угаасаа л ингэж хуваарилагдахгүй л тоонууд болж хувирна гэсэн үг.

**Ц.Даваасүрэн:** Үгүй. үгүй ингэж асуугаад байхгүй юу. Хэрвээ ноогдол ашиг авах юм байсан бол 34 хувиар авна шүү дээ тийм биз дээ? Одоо ингээд 10 хувь болгочихоор яах вэ? 10 хувь л авна. 24 хувьд авах байсан ноогдол ашгийн тэр, энэ 5 хувь чинь нөгөө нэмэлт авах хувь 2 чинь харьцангуй зөрүүтэй болчихоод байна гэж асуугаад байна тийм үү? Тэгж асуугаад байна шүү дээ. Тэгэхээр үүнийхээ тооцоог та нар сайн хийгээд Батжаргал гишүүнд бас үзүүл ээ. Итгэл үнэмшил төрүүлэх талаас. Яагаад гэвэл нөгөө ТЭЗҮ байхгүй байгаа учраас гишүүд наадхыг чинь харж боломжгүй болчихоод байгаа байхгүй юу. Тэгээд энэ талаас нь та бүгд ойлгоорой.

Г.Ганбаатар гишүүн асуулт асууя.

**Г.Ганбаатар:** Өдрийн мэнд.

Ерөнхийдөө биднүүст энэ хөрөнгө оруулалтын гэрээтэй холбоотой голцуухан эдийн засагт чухал талаас нь л яриад байна л даа. Экологи, байгаль орчин бол бүр илүү чухал. Миний хувьд бас яг энэ төсөл хэрэгжих бүс нутгаас сонгогдсон, дээрээс нь төсөл бүс хэрэгжих бүс нутагт ажиллаж, амьдарч байсан хүн байгаа юм.

Тэгэхлээр 2, 3 асуулт байна. Нэг нь гэрээтэй холбоотой эхнийхээ асуултыг асуучихъя. Тэр хөрөнгө оруулалтын гэрээний төсөл дээр 3.1-а дээр хөрөнгө оруулалт хэсэг дээр хайгуулын үед бий болсон байгууламж, дэд бүтцийг тооцож оруулах эсэхийг тодруулах хэрэгтэй байгаа юм. Энэ чинь 97 оноос хойш явсан. Арва Монгол гэж анх орж ирээд одоо сүүлдээ 17 онд Бадрах Энержи болсон санаж байна.

Ер нь яах вэ аливаа гэрээ хүчин төгөлдөр болохоос өмнө хийгдсэн хөрөнгө оруулагч талын аливаа энэ хөрөнгө оруулалтыг гэрээнд бүртгэдэггүй л дээ. Тэгээд энэ тал дээр 3.1.А, 3.1.Жи дээр хариулт авъя.

Хоёр дахь нь байгаль орчинтой холбоотой. Яах вэ энэ говийн бүсэд иймэрхүү томоохон төслүүд Оюу толгой ч бай, энэ Орано Майнинг ч бай ингээд томоохон төслүүд явахад боловсруулах үйлдвэрүүд энэ усны төслүүд маш чухал. Бид чинь говийн бүсийг энэ боловсруулах үйлдвэрлэлийг усан хангамж, усан хангамж дутагдалтай байгаа энэ бүс нутгийг усаар хангах асуудал ид яригдаж байгаа үе Засгийн газрын бас л нөгөө тэргүүлэх чиглэлд орчихсон. Энэ чиглэлээр яг энэ гэрээний хэлэлцээрт орсон заалт бий юу? Ялангуяа Хэрлэн голыг татах ч юм уу, энэ чиглэлээр дэмжлэг үзүүлэхээр үү? Эсвэл байгаль орчныг хамгаалах чиглэлээр, боловсруулах үйлдвэрлэлийг усаар хангах чиглэлээр яг энэ гэрээний явцад та бүхэн юм ярьж байна уу?

Гурав дахь асуудал нь яг орон нутагт ерөөсөө л ганц асуудал л байгаа юм л даа. Ер нь иргэд энэ эдийн засгийн томоохон төслүүдийг явахыг их эсэргүүцээд байгаа юм байхгүй байх. Гол асуудал нь энэ байгаль орчинтой холбоотой. Ялангуяа манай Дорноговь аймаг энэ Улаанбадрах, Зөөвч Овоо энэ Дулаан харын уулын орчимд газрын доорх хүхрийн хүчлээр уусган баяжуулах арга гэдэг чинь ер нь дэлхий дээр хамгийн шинэ технологи л гээд байгаа юм. Гэхдээ ирээдүйд ямар хор хохирол учрахыг одоогоор хэн ч, Казахстан ч энэ талаар хариулт өгч чадахгүй байгаа шүү дээ. Ирээдүйд юу болохыг. Манай нөхдүүд юу ярьж байна вэ гэхлээр анх байсан хэмжээнд нь саармагжуулчихна, хүхрийн сулруулсан хүчил хийх юм л гээд яриад байдаг. Энэ талаар байгаль орчныг хамгаалах чиглэлээр, тэгээд ирээдүйд учирч болзошгүй тийм мэдэхгүй шүү дээ бид тийм ээ ямар аюул, энэ талаар яг гэрээн дээр бүр тодорхой хоёр талаасаа ярилцаж байгаа юм байгаа юу? Шинэ технологи л гэдэг. Шинэ технологи гэдэг чинь одоогоор шинэ л зүйл гэсэн үг шүү дээ тийм? Хүхрийн хүчлийн үйлдвэртэй холбоотой.../минут дуусав./

**Ц.Даваасүрэн:** Их чухал асуудал асууж байна. Наранцогт гишүүн хариулчихъя. Тэгээд энэ дээр байна шүү дээ Цөмийн энерги, тэр Хими, химийн технологийн захирал энэ тэр байх шиг байна лээ. Тэр хор холбогдлын талаар. Яагаад гэвэл тэр хүхрийн хүчлийг буцаагаад шахчхаж байгаа газар руу. Тэгээд энэ нь эргээд тэр байгаль орчиндоо хэр нөлөөлж байна вэ гэдэг дээр бас хариулах юм байна шүү.

6 номерын микрофон Наранцогт.

**С.Наранцогт:** Хэлэлцээрийн үед нөгөө өмнө байгуулсан 27 жил ажилласан зүйлүүдийг яаж тусгаж байв гээд. Хөрөнгө оруулагч тал ер нь энэ өнгөрсөн хугацаанд 275 сая доллар зарсан. Энийгээ бид нар анхны хөрөнгө оруулалтад оруулах тухай бас саналыг тавьсан. Бид нар бол энийг хүлээж аваагүй. Энэ бол та нарын санк кост учраас энийг бид нар тооцох бололцоогүй гээд ингээд энийг хийсэн, тооцоонд оруулаагүй.

Гэхдээ бол яах вэ манай татварын алба эд нарын өмнөх зарцуулсан энэ хөрөнгө мөнгө дээр нь шалгалт хийж байгаа. Тэгээд энийг баталгаажуулна гэсэн. Тэгэхдээ энэ тооцоонд хөрөнгө оруулалтад тооцоогүй. Мөн дээр нь нэмээд энэ 66 сая долларын зээл хөрөнгө оруулагчаас авсан. Энийгээ бас зээлд оруулах гэдэг асуудлыг тавьсан. Бид нар энийг бас хүлээж аваагүй. Энэ зээлийг бид нар тооцохгүй. Өөрөөр хэлэх юм бол бид нар эдний хөрөнгө оруулалтад тэр баригдах үйлдвэрт оруулах 500 саяыг л анхны хөрөнгө оруулалт гэж ингэж тооцож байгаа. Энэ нэгдүгээр асуудал.

2 болоод 3 дугаар асуулт таны байгаль орчинтой учраас манай энэ мэргэжлийн ажлын хэсгийн гишүүд ажиллаж байгаа учраас энэ хүмүүс ингээд үргэлжлүүлээд нэмэлтээр хариулах нь зөв байх. Ер нь зарчмын хувьд бид нар ямар бодлого барьсан гэхээр 5 ажлын дэд хэсэг гаргаад энэ байгаль орчин, усны чиглэлээр энэ тэр яг мэргэжлийн яам өөрөө хөндлөнгийн экспортууддаа ороод ингээд бүгд энэ байр сууриа хадгалаад ингээд ажилласан. Хэлэлцээний эцсийн байдлаар энэ салбарын хүмүүс бүгдээрээ энэ өөрсдийнхөө нөхцөлийг бүрэн тусгуулж чадсан гээд тэндээ нэлээн сэтгэл хангалуун байр суурийг энэ салбарын яамнууд, энэ холбогдох мэргэжилтнүүд ингэж үзэж байгаа. Тэгээд энэ хүмүүсийг би нэмж хариулахыг хүсэж байна.

**Ц.Даваасүрэн:** Хариул тэр 9 номер устай холбогдолтой. Тэр байгаль орчинтой холбогдолтойг нь бас хариулна шүү. Тэр хүхрийн хүчлийн газар руу буцаагаад хийхээр ямар нөлөөлөлтэй вэ гэж асуух гээд байна.

9 номерын микрофон.

**З.Батбаяр:** Та бүхэнд өдрийн мэнд хүргэе. Гишүүний асуусан асуулт дээр Монгол Улсын хэмжээнд энэ гэрээний хүрээнд Монгол Улсын хэмжээнд байж байгаа усны нөөцийн бодлогыг нэгдсэн байдлаар хэрэгжүүлэх гэдэг талаасаа анхаарал тавьсан. Бүр тодруулаад хэлэх юм бол Монгол Улсад усны нөөцийн жигд хуваарилалтыг бий болгох гэдэг бодлогоо хэрэгжүүлэхийн тулд энэ говийн бүсэд хамаарч байгаа энэ төсөл маань хэрхэн яаж хэрэгжих вэ гэж.

Тэгэхээр Монгол Улсын хэмжээнд 29 сав газарт хуваарилаад 21 сав газар ажиллаж байгаа. Яг одоо төсөл хэрэгжих тал маань Галба-Өөш-Долоодын говь буюу Монголын говийн бүс гэж бидний нэрлэж байгаа хэсгийн зүүн талын хэсэг нь байж байгаа. Тэгээд Галба-Өөш-Долоодын говь дээр бусад нөгөө 3 аймагтайгаа нийлүүлээд ярих юм бол 2, 3 сав газрыг хамарч байгаа. Энэ сав газар дээр нийтдээ бидэнд 7 мянга орчим литр секундийн усны хэрэгцээ байна ирээдүйд гэж төсөөлж байгаа. Одоогийн байдлаар бид нар 3 мянга орчим литр секундийг хангах боломжтой байна.

Тэгэхээр дутагдаж байгааг газар гадаргын усыг хуримтлуулах замаар гадаргын усны хуримтлалыг нэмэгдүүлэх замаар алсын зайнд ус шилжүүлэх замаар шийдвэрлэх боломжтой юм гэдэг энэ үүднээсээ хандаж байгаа учраас бусад төслүүдтэй тодруулаад хэлбэл Орхон-Онги байдаг юм уу, Хэрлэн-Тооно байдаг юм уу, эсвэл Туул гол дээр хийж болох төслүүдтэйгээ уялдаад, холбогдоод явна гэж ингэж эхний хариултыг хэлж болохоор байна.

Хоёрдугаарт нь юун дотроо, сав газар дотроо жишээлбэл Галба-Өөш-Долоодын говь гэсэн энэ сав газар дотроо усны нөөцийн жигд хуваарилалтыг бий болгохын тулд бусад хэрэглээнүүдээ маш нарийн тодорхойлох шаардлагатай байгаа. Тэгээд энэ дээр та бүхэн хэрвээ гэрээн дээр 8.4 гэж зүйл дээр усны тухай асуудлууд байж байгаа. Энэ дээр маш нарийвчилсан усны балансыг гаргаж явна гэдэг энэ зүйлийг оруулсан нь сая Наранцогт захирлын хэлдэгтэй давуу тал болж бид нар сэтгэл хангалуун байгаа нэг зүйл нь уурхай болгон усны балансыг нарийвчлаад тооцоод эхлэх юм бол сав газар дээр усны балансаа нарийвчлаад тооцоод явах ёстой. Бидний зорилт бол.../минут дуусав./



**Ц.Даваасүрэн:** 9 гүйцээ. Чи тэр уран, нөгөө хүдрийг нь ашиглагчаад буцаагаад нөгөө хүхрийн хүчил хийхээр усанд яаж нөлөөлөхийг бас давхар хариулна шүү. 9.

**3.Батбаяр:** Санхүүгийн тооцоог нарийн хийдэгтэй адилхан усны тооцоог нарийн хийнэ гэсэн энэ тоо хэмжээ талаасаа, чанар талаасаа Байнгын хорооны даргын асуусан асуултаар бол газрын доорх уусган баяжуулах энэ технологи маань битүү хүрээнд явагдаж байгаа. Өөрөөр хэлбэл нийт ашиглаж байгаа усныхаа ойролцоогоор 95-97, 8 хувийг дахин ашиглаж байгаа. Тийм учраас гадагшаа алдагдах аюул нь харьцангуй бага.

Гэхдээ бага гээд суучих биш. Бид Монгол Улсын хэмжээнд анх удаа газрын доорх усны мониторингийн цооногуудаараа зөвхөн түвшний хэлбэлзлийг биш, харин чанаруудыг нь давхар хэмжээ гээд явах юм. Өөрөөр хэлбэл, тэр өртгийн бүсэд, нөлөөллийн бүсэд байж байгаа малчдын худгийн ойролцоо мониторингийн цооногуудыг байгуулаад энэ цооногууд дээрээ байнгын чанарын хяналт тавиад, ямар нэгэн байдлаар чанарын өөрчлөлт орж эхлэх юм бол шаардлагатай арга хэмжээг авах боломжоор хангаж байгаа. Тэгээд яг хүхрийн хүчилтэй холбоотой асуудал дээр нь манай Хими, хими технологийн хүрээлэнгийн захирал хариулах байх.

**Ц.Даваасүрэн:** Хэдэн номерын микрофон юм? 1. Та нар хариуцлагатай хариулаарай. Яагаад гэвэл энэ түүх болж үлдэнэ. Хожмын нэг өдөр энэ таны хариулт л баримт болно шүү дээ.

**Л.Жаргалсайхан:** Шинжлэх ухааны академийн Хими, химийн технологийн хүрээлэнгийн захирал Жаргалсайхан. Гишүүний асуултад хариулья.

Тэгэхээр ер нь бол 130-170 метрийн гүнд байгаа хүдрийг олборлоход 0.5-2 процентын сулруулсан хүхрийн хүчлийн уусмал ашиглана. Энэ хүхрийн хүчлийн уусмал ашигласнаараа газрын доошоогоо ингэж шахсанаараа ямар өөрчлөлт орох вэ гэхээр нэгдүгээрт усны орчин PH хүчиллэг болно. 2-3 PH нь 2-3-аас орчим болно. Тэгэхээр тэр PH өөрчлөгдөөд нөгөө хүхрийн хүчлийн маань сульфатын ион нь урантай урвалд ороод ингээд ураны комплекс үүсгээд, тэгээд дээшээгээ татагдаж гараад, тэгээд буцаад нөгөө уранаа салгачаад буцаад тэр хүхрийн хүчлийнх нь концентрац буурахаар нэмээд буцаагаад явуулна. Энэ хүхрийн хүчил хийснээрээ газрын доорх усанд PH өөрчлөгдөнө гэсэн. Дээрээс нь хүхрийн хүчилд уусаж болдог бусад элементүүд бас уусаж уусмалд шилжинэ гэсэн үг.

Тэгвэл дараа нь энэ олборлолт яваад дууссаны дараа энийг яаж нөхөн сэргээх юм бэ, яаж анх байсан хэл хэлбэрт нь оруулах юм бэ гэхээр нэгдүгээрт тэр усны орчныг саармаг хэлбэрт буюу 5-6 хүртэл нь саармагжуулах PH нь тийм болох шаардлагатай. Тэгэхээр сульфатын ионы агууламжийг бууруулах ёстой.

Тэгэхээр энийг бол одоогоор дэлхий дээр ямар технологи ашиглаж байна, яаж байна гэхээр нэгдүгээрт байгалийн жамаар нь нөгөө саармагжуулах ийм байна. Тэгэхээр нөгөө хүхрийн хүчил чинь тэр газрын доорх чулуулаг давхаргад байгаа эрдсүүд8 минералуудтайгаа ингээд урвалд орж абсорцлогдох гэх мэтээр буурах боломжтой.

Дээрээс нь химийн аргаар бууруулах, янз бүрийн аргаар химийн байж болно, физик, химийн байж болно. Ийм аргуудаар саармагжуулах боломжтой.

Тэгэхээр энийг бол ингээд албадмал болон байгалийн аргаар нь хоёулангаар нь саармагжуулж, өнөөгийн түвшинд нь хүргэх боломжтой.

**Ц.Даваасүрэн:** Тэр усанд нөлөөлөх үү гэдэгт нь хариулахгүй юм уу 9 номер? 1 номер. Гүний усанд нөлөөлөх үү гээд байна шүү дээ.

**Л.Жаргалсайхан:** Тэгэхээр энэ газар доор уусган олборлох арга усны хэрэглээ хамгийн бага зарцуулдаг ийм технологи гэж үздэг.

Яагаад тэгж байгаа вэ гэхээр ураныг нэг бол ил аргаар олборлож болно, нэг бол газрын далд уурхайн аргаар олборлож болно, нэг бол газрын доорх усны уусгалтын аргаар байж болно. Тэгэхээр ил аргаар олборлохоор ийм ухаш ухна. Нэг долд аргаар гэвэл ингээд доошоогоо хүдэр хүртлээ цооног ухаж ингэж олборлодог. Энэ үед бол газрын доорх ус хэрвээ байх юм бол шавхалт хийж байж олборлолт явдаг. Тэгэхээр нөгөө газрын доорх усыг шавхалт хийгээд маш их хэмжээний ус байгальд гаргана гэсэн үг. Тэгэхээр энэ далд уурхайгаар энэ газар доор уусган олборлох үед бол тийм ямар нэгэн газрын доорх усны шавхалт хийхгүй учраас газрын доорх усны хамгийн бага, зарцуулалт хамгийн бага технологи гэж ойлгож болно.

**Ц.Даваасүрэн:** Ганбаатар гишүүн тодруулъя.

**Г.Ганбаатар:** Жаргалсайхан дарга 4 хоногийн өмнө буюу 1 сарын 6-нд Ардчилсан намын бүлгийн хурал дээр би бас яг танаас энийг асууж байсан л даа. Та тухайн үед хүхрийн сулруулсан хүчил ашиглана. Анх байсан хэлбэрт нь бүрэн саармагжуулна л гээд байгаа юм.

Гэтэл Казахстанд байгаа эрдэмтдийн репорт янз бүрийн юм уншиж байхад яг одоогоор энэ чинь бас ингээд бүрэн саармагжуулчихсан болоод, дээрээс нь энэ газар доорх энэ уусган баяжуулах арга юу билээ энэ чинь, хүхрийн хүчлээр уусган баяжуулах арга энийг чинь ирээдүйд ямарваа нэгэн тэр юу яасан одоогоор дэлхий даяар энэ чиглэлээр хийсэн тийм судалгаа байхгүй л юм билээ.

Өөрөөр хэлбэл, яг энийг ямар нөлөөтэй хэдэн хувь нь үлдэх, ганц гарц нь оруулсан хүхрээ, өөрөөр хэлбэл, манайх өөрөө хүхрийн хүчилтэй байгаад хэдэн тонн хүхрийг газарт хийгээд, хэдэн тонн нь гарч ирснээр нь л хянах болохоос биш манайх шиг хүхрийн хүчилгүй газар бол энийг хянах боломжгүй л юм билээ шүү дээ. Тийм учраас та энэ яг энэ протокол дээр их хариуцлага.../минут дуусав./

**Ц.Даваасүрэн:** Нэмэх юм уу? Тэр усанд бол та хэдэд нөлөөлөхгүй гэж байгаа юм байна тээ гүний усанд? 1 номер.

**Л.Жаргалсайхан:** Газрын доорх ус яг хүдэр агуулж байгаа ус давхарга байна шүү дээ тэрэнд нөлөөлөхгүй гэж би ерөөсөө хэлээгүй шүү дээ. Хүхрийн хүчин шахсанаараа ямар өөрчлөлт гарах вэ? РН өөрчлөгдөнө өө, уран чинь уусаж орж ирнэ, уранаа дагаад бас тэнд байгаа хүхрийн хүчилд уусдаг элементүүд уусаж орж ирнэ гээд. Тэгэхээр нөлөөлөлгүй гэж огт хэлээгүй. Тэр үүссэн нөлөөллийг дараа нь яаж одоо байгаа энэ түвшинд нь хүргэж болох вэ гэдэг нь албадмал болон байгаль орчны, байгалийнх нь нөхөн сэргээлтээр хийх боломжтой. Хэрвээ удаандаа, аажимдаа гэвэл байгалийн нөхөн сэргээлт. Хурдан хийе гэвэл яах нь байна шүү дээ янз бүрийн аргаар боломжтой, саармагжуулж тэр РН-ийг энэ

саармаг түвшинд хүргэх боломжтой. Энийг бол би мэргэжлийн хүний хувьд хариуцлагатай хэлж байна.

**Ц.Даваасүрэн:** Заяабал гишүүн асуултаа асууя.

**Б.Заяабал:** Гишүүддээ өглөөний мэнд хүргэе.

Тэгэхлээр энэ ураныг ашиглах энэ хөрөнгө оруулалтын гэрээний асуудал орж ирж байна. Францын талтай хамтарч бас энэ олон жил бас энэ төсөл явсан. Одоо ингээд хөрөнгө оруулалтын гэрээ хийгээд олборлох ажил эхлэх энэний эхлэл болсон энэ хөрөнгө оруулалтын гэрээ орж ирж байгаа. Энийг бол ерөнхийд нь агуулгын хувьд бол дэмжиж байгаа, зарчмын хувьд бол дэмжиж байгаа. Хөрөнгө оруулалтын гэрээг байгуулаад, эдийн засгийг эргэлтэд оруулаад эргэлтэд оруулж явах нь зөв өө.

Тэгэхдээ Монгол Улсын Үндсэн хууль дээр байгаа ард түмэнд үр өгөөж нь илүү хүртэх ёстой гэдэг ийм зарчмын дагуу энэ хөрөнгө оруулалтын гэрээнд хандах нь бид нарын үндсэн үүрэг гэж ингэж үзэж байгаа. Тийм учраас манай сая зарим гишүүд асуугаад байна л даа 34 хувьтай байвал ашгаас хэдэн төгрөгийн, хэдэн төгрөгийн, бид нар үр өгөөж авах гээд байгаа юм бэ? Энэ рояалти өөрчилсөнтэй холбоотойгоор энэ нь яг нөгөө 34 хувиасаа хэдээрээ илүү бид нарт үр өгөөж нь нэмэгдээд байгаа юм бэ гэдэг ийм харьцуулсан тооцоолол хэлж өгөөч гэхлээр зэрэг энэ манай ажлын хэсэг бас тодорхой хариулж өгөхгүй байгаад байна л даа. Энэ дээрээ нэгдүгээрт бас тодорхой хариулж өгмөөр байна. Харьцуулаад та нар хийчихсэн бизнес моделиуд байгаа байлгүй дээ. Тэр дээрээ та бүхэн харь тулгуурлаад энийгээ тодорхой хариулж өгмөөр байна. Нэгдүгээрт нь.

Хоёрдугаарт нь та нараас бас шаард асуулт асуухгүйгээр ингээд харчихъя гэхээр надад энэ ТЭЗҮ энэ тооцоолол чинь бид нарт алга л даа. Хэрвээ тэр тооцоолол нь байвал бас өөрөө ороод харчихмаар байх юм.

Тэгээд зарим Байнгын хороонууд дээр энэ ТЭЗҮ нь батлагдаагүй гэдэг юм яригдаад байна гэх юм. Сая энэ яг батлагдсан юм уу, батлагдаагүй юм уу гээд сая Батжаргал гишүүн асуувал бас хариулахгүй ингээд өнгөрчих юм. Тэгэхлээр энэ ТЭЗҮ нь хийгдээгүй байгаа нөхцөлд хөрөнгө оруулалтын гэрээг хийх ер нь боломж байгаа юм уу? Үр өгөөжтэй гэдгийг яг хэн тодорхойлж яг тэрийг тогтоож чадах юм бэ? Эцсийн хариуцлагыг нь хэн хүлээх юм? Энэ дээрээ бас тодорхой хариултыг өгмөөр байна гэдгийг бас хэлэхийг хүсэж байна.

Мөн энэ эхлэлийн балансыг энэ “Бадрах Энержи” компани Монголд үйл ажиллагаа явуулаад зөндөө удчихсан. Одоо яг энэ хөрөнгө оруулалтын гэрээ, үйл ажиллагаа эхэлсэнтэй холбоотойгоор эхлэлтийн баланс нь яг хэд байгаа юм бэ гэдэг дээр бас тодорхой тоотой баймаар байна. Сая Наранцогт захирал тэр татварынхан хяналт шалгалт хийгдэж байгаа энэ ажил нь явагдаж байгаа гэсэн зүйл ярьж байх юм. Одоо энэ хөрөнгө оруулалтын гэрээ гарахад чинь тэр нь тодорхой тооцогдчихсон байх ёстой шүү дээ. Дараагийн олох орлогоос тэр дүнгүүд чинь хасагдаж явах ёстой татвараас. Тэгэхлээр энэ тооцооллууд чинь бэлэн болчихсон байх ёстой гэдэг дээр би бол асуулт асуумаар байгаа юм. Татварын тооцооллууд дээр бас нэлээдгүй дэлгэрэнгүй мэдээллүүдийг авмаар байна. Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар, НӨАТ, АМНАТ гаалийн татварыг бол ингээд тогтворжуулсан гэж оруулж ирсэн байна. BEPS-ийг бас хэрэглэе гэж ингэж орж

ирсэн байна. Уг нь BEPS бол олон улсын гэрээ учраас Монгол Улсын энэ хоёр талын хөрөнгө оруулагчийн.../минут дуусав./

**Ц.Даваасүрэн:** Минутаа одоо авчих юм уу? 1 минутыг нь өгье Заяабал гишүүний.

**Б.Заяабал:** Олон улсын гэрээнээс давах боломжгүй л дээ. Энэ Би Эф Си/BFC/-г хүссэн, хүсээгүй л бид нар мөрдөөд явах ёстой. Оюу толгой дээр бас яг л ийм асуудал үүсдэг. БИ ЭФ СИ/BFC/-ийг хүлээж авахгүй гэдэг ийм заалт оруулаад ирчихсэн. Тэрэнтэйгээ холбоотойгоор ингээд татварын алба дээр одоо хүртэл маргаан нь явж байгаа. Харин энэ дээр Би Эф Си/BFC/-ийг хүлээж авна гээд ингээд оруулаад ирчихсэн нь сайшаалтай боловчиг энэ нь олон улсын гэрээ учраас энэ нь хүлээж авах ёстой.

Ноу Хау маркетингийн зардал гээд ороод ирчихсэн байна. Нөгөө Оюу толгой дээр байдаг менежментийн зөвлөх үйлчилгээ, стратегийн зөвлөх үйлчилгээ гэдэгтэй адилхан юм л ороод ирчихсэн байх шиг байх юм. Тэгээд энэ дээрээ энэ 5.4.Си дээр энэ ноу хау маркетингийн төлбөрүүдийн хувь хэмжээ татварын зорилгоор бодит үнэ тодорхойлоход ашиглагдахгүй гэдэг нь юу гэж байгаа юм? Эндээс суутган татвар авахгүй гэж байгаа юм уу?

Дээрээс нь энэ нэмэгдсэн өртгийн албан татварыг “тэг” хувь хэмжээг хэрэглэхээр ингээд ороод ирчихсэн байгаа юм. Тэгээд модель дээрээ яг хэчнээн хэмжээний нэмэгдсэн өртгийн албан татвар гэж гарч ирээд тэрийг нь тэг хэмжээгээр олгохоор байгаа юм бэ? Энэ нь эргээд үр өгөөжийг чинь буулга.../минут дуусав./

**Ц.Даваасүрэн:** Хариулья 5 номер, Учрал сайд.

**Н.Учрал:** Тийм. Өнгөрсөн хугацаанд бол туршилтын үйлдвэр жилийн хугацаанд туршилтаа бол хийсэн юм байна лээ. Тэгээд дараа нь Ерөнхий сайдын захирамжтай энэ ажлын хэсгүүд гараад тэгээд тэр Ерөнхийлөгчийн айлчлалын үеэр протоколд зурагдсанаар бол анх яг тэр 34 хувиа орлуулъя. Орлуулахдаа тодорхой АМНАТ-аар дахиад эрхийн хувьцаа авъя гээд. Энэ зарчмынхаа дагуу л бид нар ийм санхүүгийн схемээ өөрсдөө гаргасан. Энэ хүрээнд бол энэ олон улсын санхүүгийн “Си Ар Эй” зөвлөх үйлчилгээний компани, дотоодын санхүүгийн зөвлөхүүд ажиллаад анх удаа бид нар хөрөнгө оруулалтын гэрээг өөрсдийн санхүүгийн модельтой болж байж өөрсдийнхөө санхүүгийн модель дээр яг 1 фунт ураны үнэ 80 байвал хэд байх юм, 90 байвал хэд байх юм, 70 байвал хэд байх юм гээд яг орчин үеийн тренд энэ санхүүгийн зах зээлийн мэдээллүүдээсээ аваад ингэж хийсэн.

Тэгэхээр мэдээж санхүүгийн модель юм хөдөлшгүй байна гэж байхгүй шүү дээ. Мэдээж КОВИД шиг зүйл бол ч гэдэг юм уу энэ тохиолдолд бол санхүүгийн моделийг эргэж харах нөхцөл үүснэ. Тийм динамик байна. Гэхдээ ер нь хөрөнгө оруулалтын гэрээг хийхдээ энэ удаа өөрсдөө санхүүгийн модельтой болж хийх нь зөв. Яагаад гэвэл Үндсэн хуулийн 6.2 дээр энэ байгалийн баялгийн дийлэнх дийлэнх ард түмэн эзэмшинэ гээд бид нар тийм босго тавиад өгчихсэн. Энэ босгыг хангуулахад л зорихгүй бол бид нар Үндсэн хууль зөрчсөн асуудал үүснэ. Тийм учраас энэ босго шаардлагаа хэрхэн давах вэ гэдэг босго байсан учраас манай санхүүгийн модель тийшээ л чиглэсэн. Тийм учраас бид нар ийм хоосон яриагаар

биш энэ санхүүгийн зөвлөхүүд байна л даа. Эд нар бол яг тэр модель дээрээ үндэслээд ингээд харуулж байгаа.

Тэгэхээр Заяабал гишүүнд бол бид яг энэ нарийн тооцоолол, мэдээллийг бас бид бас харуулж болно. Их Хурал бол мэдээж нөгөө хөрөнгө оруулалтын гэрээг зөвшилцөх ийм хуультай учраас бид нар хуулийнх нь дагуу ингээд зөвшилцөхөөр л ингэж хүргүүлж байгаа. Монгол Улсад ноогдох өгөөж гэж яг юуг үзэх юм бэ гэдэг дээр нэлээдгүй хэлэлцээ үргэлжилсэн. Жишээ нь тэр ус бохирдуулсны төлбөрийг бид нар Засгийн газрын өгөөжид чинь тооцно доо ч гэдэг юм уу ийм ярианууд зөндөө гаргасан. Үгүй ээ, энэ бол бохирдуулсан учраас тийшээгээ зарж байгаа учраас манай аваад байгаа өгөөж биш шүү ч гэдэг юм уу. Ингэж явсаар байгаад 13 төлбөр, татварыг л бид нар яг манай өгөөж ингэснээрээ тэр 51 хангуулна гэж тооцоо. Хэрвээ зах зээлийн үнэ нь буурчих юм бол түүн дээр нь өгөөжөө тохируулъя гэдгийг нь харин хөрөнгө оруулалтын гэрээндээ хийж авсан.

Тэгээд үүн дээр, санхүү дээр ч гэсэн яг хэдэн төгрөг байх вэ гэдгээ тооцож явж байгаа. Ингээд Монгол Улсад ноогдох мөнгөн урсгалуудыг бүтцээр нь 100 хувь гээд аваад үзэх юм АМНАТ-аас 37.6 хувь, аж ахуйн нэгжийн орлогын албан татвар 36.5, Давуу эрхийн ноогдол ашиг 11.5, ноогдол ашгийн суутган татвар буюу нөгөө тал 90 хувийн ноогдол ашиг авч байгаа бол тэндээс нь суутган татвар, тогтвортой хөгжлийн арга хэмжээ 0.9. Мөн гаалийн албан татвар, мэдээж энэ чинь үйл ажиллагаа явж байгаа учраас ингээд гаалийн албан татвар авна, Нийгмийн даатгалын шимтгэл, тусгай зөвшөөрлийн төлбөр, үл хөдлөхийн татвар, төлбөр, ус ашигласны төлбөр, үр өгөөж, тэнцвэржүүлэх механизм 2.3 гээд нийтдээ 100 хувь гэж ингэж авч бол үзэж байгаа. Тэгээд ер нь хэрвээ 34-ийг шууд авахаараа ноогдол ашиг нь 5.6 тэрбум доллар харагдаж байсан мөртөө нөгөө эрсдэлтэй нь 82 хувийг хангаад байсан учраас эрсдэлийг бууруулах чиглэлээр энэ орлуулж байгаа нь бууруулахад бололцоотой гэдэг нь энэ санхүүгийн схем дээр тодорхой харагдаж байсан учраас бид нар ингэж тооцоолж ингэж хийсэн.

Тэгээд үүндээ үндэслээд бид нар хөрөнгө оруулалтын гэрээ хийж, боловсруулаад манай хөрөнгө оруулалтын гэрээний үндсэн драфт дээр нөгөө тал саналуудаа хэлээд хий.../минут дуусав./

**Ц.Даваасүрэн:** 1 минут нэмье.

**Н.Учрал:** ТЭЗҮ дээр бол батлагдаагүй гэж ярьж болохгүй. ТЭЗҮ-ийг бол Аж үйлдвэр, эрдэс баялгийн зөвлөл дээр яг энэ Цөмийн энергийн хууль батлагдсаны дараа хүртэл орж танилцуулсан. Яг эцсийн алх цохиогүй байгаа. Энийг л буруу ойлгоод байх шиг байна. Яагаад вэ гэхээр Их Хурлын тогтоол буюу 3 ... тусгай зөвшөөрлийн хүрээнд хамаарах энэ төсөл дээр АМНАТ-аар орлуулах, давуу эрхийн хувьцаагаар орлуулах тогтоол гараагүй байгаа. Ингээд Их Хурлын тогтоол өнөөдөр, өчигдөр батлагдсан.

Ингээд төрийн мэдээлэлд хэвлэгдээд ингээд явахад бид нар бол ТЭЗҮ бүрэн учраас сүүлд алх цохих л асуудал яригдахаас биш ТЭЗҮ бол бүрэн боловсруулаад дууссан. Өнөөдөр ярьж байгаа зүйл бүгд ТЭЗҮ дээрээ суурилсан, санхүүгийн модель дээрээ суурилсан ийм л хөрөнгө оруулалтын гэрээ. Бидний драфт, бидний санхүүгийн модель. Тэрнээс биш хүний хийсэн, нөгөө талын хийсэн зураг дээр ажиллаагүй л гэсэн үг.

Ингээд нэмэлт мэдээллүүдийг өгөөд явчихъя.

**Ц.Даваасүрэн:** Харин тэр нөгөө зөрүү нь тэгээд ашигтай байгаа юм бол ямар зөрүү гараад байгаа юм бэ гээд байна шүү дээ. 34 хувийн ноогдол ашиг авахаар, эсвэл нөгөө АМНАТ-аар орлуулчихаар яагаад ашигтай болчихоод байгаа юм? Хэчнээн хэмжээний зөрүү гараад байгаа юм гэдэг л Батжаргал гишүүн, Заяабал гишүүн асуугаад байна шүү дээ. 7.

Ер нь тэр ТЭЗҮ нь хийгдчихсэн юм гишүүдэд тараачхаач дээ. Тэгээд гишүүд бас тэрийг нь хараг л дээ.

**Л.Энх-Амгалан:** Заяабал гишүүний асуултад хариулъя. Эдийн засаг, хөгжлийн яам Энх-Амгалан.

Түрүүн би хэлсэн нөгөө төслийн хугацаанд нийт ашиг нь 5.5 тэрбум доллар гэж гарч байгаа. Үнийг 80 доллароор бодоход, тэр 24 хувийг тусгай АМНАТ-ын 5 хувиар орлуулж байгаа. Энэ 5.5 тэрбумын ноогдол ашгаар хуваарилбал жилдээ 40 хувийн ноогдол ашгаар хуваарилна гэвэл, жилдээ 40 хувийн ноогдол ашгаар хуваарилаад түүнийх нь 24 хувь нь хэд вэ гэхээр 530 сая доллар болж байна. Тэгэхээр үнийг 80 хувь дээр бодоход тусгай АМНАТ нь өөрөө 730 сая доллар болж байгаа. Тэгэхээр энэ нь яг ингэж шилжүүлсэнтэй холбоотойгоор яг төсөвт орж байгаа орлого нь 200-гаад сая доллароор илүү байгаа гэдгийг хэлье.

**Ц.Даваасүрэн:** 200 саяд бол. Тэгэхдээ 50 хувийн өсөлт гарахгүй бол байхгүй л юм байна лээ шүү дээ. Юмыг бас жоохон үнэн ярина шүү. Тэр чинь 50 доллароос дээш болж байж л тэрийг чинь авах юм байна лээ шүү дээ. Тэр нэмэлт, тэр тусгайг чинь. Тэрнээс дээш болж байж авах байхгүй юу. Тэрнээс дээш болоогүй тохиолдолд авахгүй байхгүй юу. 5.

**Н.Учрал:** Тийм. 50 доллароос доош орчих юм угаасаа үйлдвэр зогсоно. Тэгээд ашиг гэдэг ойлголт байхгүй шүү дээ.

**Ц.Даваасүрэн:** Үгүй, үйлдвэр зогсоно гэж байхгүй шүү дээ. Тэр чинь чи худлаа яриад байх юм. Өсөн нэмэгдэх, 50 доллароор өсөн нэмэгдүүл гэж байгаагаас юу гэж үйлдвэр зогсох юм бэ? Үйлдвэр зогсохгүй.

**Н.Учрал:** Үгүй үгүй үнэ нь 50-аас доош орчих юм бол.

**Ц.Даваасүрэн:** 50, бишээ өсөн нэмэгдэх нь 50 доллароос дээш тийм биз дээ? Хариул даа. 7.

**Н.Учрал:** Өсөн нэмэгдэх нь тийм.

**Ц.Даваасүрэн:** Тийм, тэгэхээр чинь юу гэж зогсдог юм бэ? Үйлдвэр зогсохгүй. Тэгэхээр 50 доллароос дээш өсөн нэмэлт гарахгүй бол авахгүй байгаа байхгүй юу.

4 хариулах гэж байна уу, үгүй юү? Жавхлан сайд 4.

**Б.Жавхлан:** Заяабал гишүүний асуусан тэр нөгөө зардалтай холбоотой, ноу хау болон бас маркетингийн зардал гэж бас байгаа. Хэлэлцээрийн явцад ер нь бид олж авч чадсан хэд хэдэн онцлох ийм давуу тал, амжилтуудын маань энэ

байгаа гэж харж байгаа шүү бид нар. Энэ юу вэ гэхээр яах вэ Оюутолгойтой харьцуулж ярихаар их ойлгомжтой харагдаад байгаа юм. Оюу толгой дээр бид яаж байсан бэ гэхээр энэ маркетингийн зардлуудаа, менежментийн зардлуудаа аваачаад зардал дотор нь шингээчихсэн. Тэрийг нь зөвшөөрөөд, өгөөжид нь тооцохгүйгээр.

Өөрөөр хэлбэл, нэгэнт өгөөжид тооцохгүй, тэгээд зардал дээрээ бүртгэгдээд явж байгаа учраас энийгээ өсгөх замаар өртөгтөө шингээгээд цаад талдаа ингээд цаад талдаа ингээд үр өгөөж авах ийм боломжийг нь нээлттэй орхичихсон тэнд. Энэ удаа харин бид нар нөгөө талын 49 хувийн өгөөж дотор нь энийг чинь оруулж тооцно шүү гэхчээр энэ хязгааргүй өсгөх тэр боломжийг нь ингээд хязгаарлачхаж байгаа юм. Хэрвээ энийг өсгөх юм бол манай 51 хувь даваад өснө. Ийм учраас.../минут дуусав./

**Ц.Даваасүрэн:** 4 номерыг 1 минутаар.

**Б.Жавхлан:** Тийм энийг зөвшөөрүүлж чадсан нь бол бид 51 хувийнхаа тогтмол өгөөжийг хамгаалж чадсан. Дээрээс нь энэ төрлийн зардлыг хэмжээ хязгааргүй өсгөх тэр эрсдэлийг нь бас давхар хаачхаж байгаа юм. Тийм учраас энэ гэрээнд хийгдсэн бас давуу талын юм гэдгийг үүгээр ингэж онцолж хэлэх байна.

Мөн нөгөө талаар энэ маркетингийн зардал жишээ нь, татварын зорилгоор хасагдах зардалд тооцохгүй гэдгийг мөн зөвшөөрүүлж чадсан байгаа. Ингэж гэрээндээ оруулж чадсан.

**Ц.Даваасүрэн:** Ийм зүйл асуугаад байгаа байхгүй юу. Одоо ингээд нөгөө тогтворжуулчихсан байгаад байгаа шүү дээ. Тэгэхээр энэ компани хоорондын гэрээ юм уу, олон улсын гэрээ юм уу гэдэг асуудлыг асуугаад байна шүү дээ. Хэрвээ олон улсын гэрээ заавал бол Их Хурлаар соёрхон батлах ёстой. Зөвшилцөх биш. Их Хурлаар соёрхон баталж байж татвар тогтворжих болох байхгүй юу. Хуулиас илүү хүчинтэй болж байж. Олон улсын гэрээ болж байж тэр Заяабал гишүүний хэлээд байгаа тэр байхгүй юу, олон улсын гэрээнд өөрөөр заасан бол түүнийг дагана гэж Татварын ерөнхий хууль дээр байгаа байхгүй юу. Тэгэхээр одоо бид нарын яриад байгаа чинь олон улсын гэрээ юм уу, зөвшилцөж байгаа юм уу гэдэг асуудал байгаа байхгүй юу. Гэтэл энэ гэрээн дээр чинь татварыг тогтворжуулчихсан байна шүү дээ.

Тэгээд Оюу толгой дээр яг ийм маргаан үүсээд яваад байгаа байхгүй юу. Тэгэхээр энэ чинь олон улсын гэрээ юм уу, зөвшилцөөд байгаа юм уу гэж асуугаад байна шүү дээ? 3.

**Б.Тэлмүүн:** Сангийн яам Татварын бодлогын газрын дарга Тэлмүүн.

Энэ гэрээ бол Цөмийн энергийн хуулийн 30 дугаар зүйлд заасан хөрөнгө оруулалтын гэрээ гэсэн зүйлийн дагуу орж байгаа гэрээ энэ 30 дугаар зүйлд юу гэж заасан гэхээр Хөрөнгө оруулалтын гэрээ. Хөрөнгө оруулалт.

**Ц.Даваасүрэн:** 30 дугаар зүйл хамаагүй. Би чамаас ийм юм асуугаад байна шүү дээ. Татварын хуулийн заалтыг асуугаад байна шүү дээ. Татварын хууль дээр. Олон улсын гэрээнд өөрөөр заасан бол түүнийг дагана гэж байгаа шүү дээ. Тэрнээс Цөмийн энергийн хууль дээр гэж байхгүй байхгүй юу.

Тэгэхээр олон улсын гэрээгээ мөн юм уу, аль эсвэл компани хоорондын гэрээ юм уу, татварыг тогтворжуулах чадвар байгаа юм уу хуулийг давж гэж асуугаад байна шүү дээ.

**Б.Тэлмүүн:** Татварын ерөнхий хуулийн 4.1.1-д хөрөнгө оруулалтын төсөл хэрэгжүүлэх хуулийн этгээдийн тогтворжуулах татварын орчныг Цөмийн энергийн хуульд заасны дагуу тогтоож болно гэдэг эрхийг хуулиараа олгосон. Татварын ерөнхий хуулиар. Мөн Цөмийн энергийн хуулийн 30 дугаар зүйлээр Хөрөнгө оруулалтын гэрээ нь тогтворжуулах татварын орчныг тогтоох гээд 2024 оны 11 сарын 21-ний өдөр Улсын Их Хурал хууль баталж өгсөн. Энэ хуулиараа татварын, тогтворжуулах татварын орчинд татварын хувь хэмжээ, элэгдэл тооцох хугацаа, алданги шилжүүлэх хугацаа энэ 3 үзүүлэлтийг тогтворжуулж болно гэсэн. Энэ хүрээндээ хэлцэл хийгдээд орж байгаа.

Тэгэхээр энэ хэлэлцээ бол Татварын ерөнхий хууль, Цөмийн энергийн хуульд нийцэж орж байгаа.

**Ц.Даваасүрэн:** Маргаан үүсгэхгүй гэж байгаа юм байна. Болчихсон уу? Тодруулъя. Тэр зүйл асуугаад байгаа байхгүй юу.

**Б.Заяабал:** Би дахиад тодруулаад НӨАТ-ыгаа эргээд асуучихмаар байна. Энэ НӨАТ дээр тэгээд та нар яг хэдийг олно гэж тооцсон юм? Яг тэр тооцсон дүнгээр чинь буцаагаад “тэг” хувь хэрэглэхээр буцаагаад тэр татварынхаа төлсөн, нэмэгдсэн өртгийн албан татвараа буцаагаад авчихна шүү дээ.

Тэгэхлээр энэ чинь эргээд нөгөө хүртэх ёстой үр өгөөж чинь буурах ийм асуудал үүсэх юм биш үү? Та нарын тооцоогоор яг хэд байгаа юм бэ модель дээр чинь? Тэгээд моделио өгнө гээд байх юм. Гол нь урьдчилаад өгчихвөл уг нь их л байна л даа. Тэгээд ерөөсөө ТЭЗҮ, модель ерөөсөө өгөхгүйгээр ингээд үг, үсгээр орж ирээд ийм байгаа юм, тийм байгаа юм гээд яриад байхаар л харанхуй л тэгээд л энэ гэрээг л дэмжиж явах л ийм л асуудал үүсчих гээд байх юм. Тэгэхлээр энэ дээрээ та бүхэн бас тодорхой хариулт өгөөч. Тэр модель дээр чинь тэр зардлын асуудлууд байна. Жишээлбэл тэр хүхрийн хүчлийгээ хэдээр тооцож байгаа юм? Эхэндээ бол энэ чинь гаднаас импортоор оруулж ирнэ. Хэдээр тооцож байгаа юм, дараа нь хэдээр яах юм? Дээрээс нь тэр хүхрийн хүчлийг шахахтай холбоотой гаргах дээр эрчим хүч үйлдвэрлэх асуудал энэ дээр орж байна шүү дээ.

**Ц.Даваасүрэн:** 5 номерын микрофон Учрал сайд.

**Н.Учрал:** Тийм ТЭЗҮ-ийг танд тухайлан харуулж болох байх.

Тэрнээс биш өнөөдөр дэлхий дахин их цочирдож ч хүлээж авлаа шүү дээ. Дэлхийд анх удаа ураны гэрээг ил болголоо шүү дээ Монгол Улс. Тэгээд ТЭЗҮ чинь яг үнэндээ энэ чинь хувь нийлүүлэгчид хоорондын энэ чинь ноу хау технологитой холбоотой асуудал шүү дээ. Компанийнхаа хууль, компанийн нууцын асуудал бас байдаг шүү дээ. Тэгээд ТЭЗҮ-г нь бүгдийг нь ил болгочих юм уу?

**Ц.Даваасүрэн:** ТЭЗҮ гэдэг чинь ил байдаг зүйл Учрал сайд аа битгий хачин юм яриад бай. ТЭЗҮ ил байж байж эдийн засгийн үр ашгийг чинь тэр төсөл чинь ашигтай юу, үгүй юу гэдгийг ярьдаг юм.

**Н.Учрал:** Үгүй ээ бид хэлэлцээний явцад.../үг тасалдав./



**Ц.Даваасүрэн:** Нууцын тухай хуульд байхгүй наадах чинь. 5 номерын микрофон. Бас битгий хамаагүй тэгээд худлаа зэрөөд бай л даа.

**Н.Учрал:** Үгүй. үгүй зэрөөд байгаа юм байхгүй.

**Ц.Даваасүрэн:** Та нар чинь Их Хурал дээр хариулж байна шүү дээ.

**Н.Учрал:** Зэрөөд байгаа юм байхгүй.

**Ц.Даваасүрэн:** ТЭЗҮ нууц байна гэж хаана байдаг юм.

**Н.Учрал:** Үгүй үгүй ТЭЗҮ чинь Нө хау технологитой холбоотой учраас энэ хэлэлцээний явцад бол энийг шууд ил гаргаад тавих нь зохимжгүй гэж.

**Ц.Даваасүрэн:** ТЭЗҮ гэж байна шүү дээ наадах чинь. Юу нь технологи. ТЭЗҮ гэдэг чинь энэ төслийг хэрэгжүүлбэл үр ашигтай юм уу гэсэн үг байхгүй.

**Н.Учрал:** Аж үйлдвэрийн зөвлөлөөр батлагдаагүй байна. Яагаад гэвэл Их Хурлын тогтоол албажингуут яг албажих гээд байгаа байхгүй юу. Тийм учраас бид Их Хурлын тогтоолыг хүлээгээд хэлэлцээд ингээд шийдвэрлээд дууссан. Яг ингээд эцэслээгүй байсан байхгүй юу. Тийм учраас ТЭЗҮ-г шууд олон нийтэд ил тавихаас илүү гишүүдэд тухайлан манай энэ ажлын хэсгийнхэн харуулаад явах нь зөв өө гэдэг ийм саналыг л хэлээд байгаа юм.

**Ц.Даваасүрэн:** Гүйцэт батлагдаагүй л байгаа юм байна шүү дээ. Нөгөө орлуулахыг нь шийдэж байж яах гээд байгаа юм байна.

**Н.Учрал:** Орлуулах нь шийдэгдээгүй байсан юм.

**Ц.Даваасүрэн:** Тэгэхээр тэр орлуулах юмаа ингээд батлагдчихаар ер нь гишүүдэд тэрийгээ тараагаад энэ ингээд та нар үр ашигтай гэж яриад байгааг бас гишүүд тэр ТЭЗҮ дээрээс харж харж итгэл үнэмшил болъё гээд байгаа нь бас буруу биш л дээ.

Номинчимэг гишүүн асуултаа асууя.

**О.Номинчимэг:** Баярлалаа. Энэ олон жил гацаж байгаа бас энэ төсөл урагшлаад өнөөдрийн бас Улсын Их Хурлаар хөрөнгө оруулалтын гэрээг нь зөвшилцөхөөр орж ирж байгаад хувьдаа бол баяртай байна. Энэ төсөл бараг 20 гаруй жил явж байсан дунд нь Японы хөрөнгө оруулагч нар ч гэсэн орж ирээд хууль, эрх зүйн орчин нь тодорхойгүй, Засгийн газар ямар бодлого барих гэж байгаа нь тодорхойгүй гээд олон шалтгаанаас болоод гарсан. Явах гэж байгаа үгүй нь гуравдагч хөршийн хөрөнгө оруулалт гээд мэдэгдэхгүй байж байгаад одоо энэ Засгийн газрын үед, энэ Улсын Их Хурлын үед энэ төсөл ингээд шийдэгдээд явж байгаад баяртай байна. Хөрөнгө оруулалтын гэрээтэй богинохон хугацаа байсан боловч танилцлаа.

Ер нь бол олон улсын стандартын хувьд бас энэ Засгийн газар дээр байгуулагдсан олон талын бас ажлын хэсэг байгуулагдаад богино хугацаанд сайн ерөнхий рамаа бол маш сайн гаргасан байна гэж харж байна. Тэгээд мэдээж энэ хөрөнгө оруулалтын гэрээ өөрөө маш нарийн хөрөнгө оруулагч болон манай

Монгол Улсын Засгийн газар улсын хооронд энэ нарийвчилсан харилцааг ерөнхий рампыг нь гаргаж байгаа. Тэгээд энэнээс гадна бол энэ гэрээ хийгдсэний дараа хувьцаа эзэмшигчдийн гэрээ, уурхайн олборлолтын гэрээ гээд нарийвчилсан юмнууд дээр өшөө нарийн бас харах юмнууд байгаа. Нэлээн ерөнхий рамуудаа эндээ оруулж өгсөн юм байна гэж харж байгаа.

Тэгэхээр яах вэ Төсвийн байнгын хороон дээр болохоор төсөв санхүүтэй холбоотой тодруулах асуудлуудаа асуучихъя. 2, 3 асуудал байна.

Нэгдүгээрт бол энэ давхар татвартай, татвартай холбоотой асуудал байна. 4 дээр нөгөө дайркт бенефит/direct benefit/ буюу төслийн шууд үр өгөөж гээд Монгол Улсын хувьд авах төслийн шууд үр өгөөж нь юу байх юу байх вэ гэдгийг ингээд оруулсан байгаа. Энэ дээр 2 асуулт байгаа нь нэгдүгээрт энэ ус ашигласны төлбөр гэж байгаа тээ? Энэ ус ашигласны төлбөр манай Монгол Улс усны байдал ямар байгаа билээ энэ төлбөрөөс ер нь энэ төслийн хүрээнд ямар хэмжээний төлбөр цугларна гэж үзэж байгаа юм? Энийг заавал оруулах тийм тооцоолол хэрэгтэй байсан уу гэдэг дээр хариулт авъя.

Хоёрдугаарт, суутган татварын асуудал байна. Монгол Улс, Франц улс 2 давхар татварын гэрээтэй. Тэгээд Монгол Улсын шууд авах үр өгөөж дээр болохоор хөрөнгө оруулагч талын ноогдол ашгийн суутган, мөн хэрвээ зээл эд нар олгох юм бол хүүгийн суутганыг бол тооцсон байгаа. Тэгэхээр яг энэ энэ 2 улсын давхар татварын гэрээний хувьд одоо ч гэсэн мэдээж практик нь байгаа байх. Яг энэ давхар татварын суутган татвар манай Монголдоо төлөгдөж байгаа юу? Эсвэл гэрээнийхээ дагуу энэ чинь алинаар нь ч байж болохоор давхар татварын гэрээ маань 10, 11 дүгээр бүлэг дээр зохицуулагдсан байгаа. Яаж явж байгаа вэ гэдгийг тэгээд тэрний тооцоолол ер нь энэ хугацаанд ямархуу үр өгөөж жилдээ авна гэж бодож байгаа вэ гэдэг дээр тооцоолол байвал хэлж өгөөч

Хоёрдугаарт, энэ өнөөдөр өчигдөр тараасан хувилбар биш, 12 сарын сүүлд тараасан ийм ном хэлбэртэй хувилбар төслийн гэрээ байгаа юм. Энэ төслийн гэрээний хамгийн эхний оршил хэсэг, үндэслэл хэсгийн Эйч.../минут дуусав./

**Ц.Даваасүрэн:** Номинчимэг гишүүнд 1 минут өгье.

**О.Номинчимэг:** Эйч дээр болохоор 22 оноос файлет хэрэгжүүлээд 10 тонн орчим ураныг экстракшн энэ процессинг хийсэн гэсэн ийм мэдээлэл байгаад энэ дээр байхгүй болчихсон байна л даа. Тэгэхээр энэ ойлголт зөв үү? Нөгөө файлет прожектын хувьд 10 тонн уран гаргасан юм уу, эсвэл нийт төслийн маань 10 тонн уран гаргана гэдэг юмаа энэ дээрээ биччихсэн байгаа юм уу? Хэрвээ нөгөө файлет төслөөр уран гаргаж авсан энэ Бадрах Энержи өөрөө Мон-Атом оролцсон, хамтарсан компани байгаа. Бадрах Энержи, Мон-Атом-ын хувьд эндээс ашиг хүртсэн юм байгаа юу? Үүнтэй холбоотойгоор компанийн өөрийнх нь хөрөнгө оруулалт санхүүгийн байдлыг бас тодруулмаар байна. Ер нь бол гэрээний хугацаа, энэ хөрөнгө оруулалтын гэрээний хугацаа 20 жил. Гэхдээ төслийн хугацаагаа хэд гэж үзэж байгаа юм? Анхны констракшн фэйс буюу барилгын хугацаа нь 4 жил. Эндээ 500 сая доллар байсан уу тээ, оруулна. Нийтдээ нэг аравны, 1 тэрбум 650 сая долларын хөрөнгө оруулалтыг хөрөнгө оруулагч хийнэ гэсэн байгаа. Тэгээд эндээс ихсэх юм бол зээл авч магадгүй. Гэхдээ яг энэ та бүхний тооцооллоор төсөл.../минут дуусав./

**Ц.Даваасүрэн:** Хариулъя. Хэдэн номерын микрофон хариулах вэ? 3.

**Б.Тэлмүүн:** Сангийн яам Татварын бодлогын газрын дарга Тэлмүүн. Давхар татварын гэрээтэй холбоотой асуултад хариулъя.

Монгол Улс Франц Улстай 1994 онд үзэглээд, Давхар татварын гэрээ үзэглээд 99 онд үйлчилж эхэлсэн байдаг. Энэ гэрээний дагуу ноогдол ашгийн орлогод 5-аас доош хувийн оролцоотой бол 10 хувь, бусад тохиолдолд 15 хувийн ноогдол ашгийн суутган татвар, хүүгийн орлогод 10 хувийн суутган татвар, эрхийн шимтгэлд 5 хувийн суутган татвар гэсэн ийм байдлаар ноогдуулах гэрээ үйлчилж байгаа. Энэ Монгол Улсын олон улсын гэрээ учраас дотоодын хууль тогтоомжид өөрөөр заасан бол энэ хувиуд хэрэгждэг. Эдгээр нь бүгд суутган татвар. Монгол Улсаас Франц улс руу орлого шилжүүлсэн тохиолдолд Монгол Улсын татварын алба хурааж авдаг, орлого шилжүүлсэн тал нь суутгах ийм үүрэг хийсэн байдаг.

Давхар татварын гэрээтэй холбоотойгоор хамгийн гол асуудал бидний хувьд давхар татварын гэрээг урвуулан ашиглаж татвараас зайлсхийх ийм эрсдэл үүссэн тохиолдолд яах вэ гэдэг асуудал байгаа.

Тэгэхээр энэ асуудлыг бид гэрээний 5.4-д татвараас зайлсхийхийн эсрэг энэ тусгайлсан зүйлийг оруулсан. Энэ дээр олон улсын эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын дүрэм журмууд татвараас зайлсхийхийн эсрэг энэ конвенц Монгол Улсын хуулиар давхар татварын гэрээг оруулж ашиглах энэ заалтуудын эсрэг бид нар хамгаалалтаа авч үлдсэн. Тэгэхээр давхар төрийн гэрээтэй холбоотой эрсдэл бол үүсэхгүй ийм байдалтай байгаа.

**Г.Манлайжав:** 9 номер Номинчимэг гишүүний асуултад нэмэлт хариулъя. Манлайжав Цөмийн энергийн комисс.

“Бадрах Энержи” компани бол туршилтын үйлдвэрлэлийг явуулсан. Энэ хугацаанд нийтдээ 24 тонн шар нунтаг гэж бид нар нэрлэдэг. Тэгэхдээ тэр бол Амоним диоранат гэдэг ийм эмийн найрлагатай 10.4 тонн бол уран руу хөрвүүлсэн экваленттэй ийм шар нунтгийг туршилтаар гаргаж авсан. Цөмийн энергийн тухай хуулийн дагуу бид нар өнгөрсөн онд анх удаа цөмийн бодисын тусгай зөвшөөрлийг хадгалах, ашиглах зөвшөөрлийг олгосон. Тэгээд “Бадрах Энержи” компани энэ тусгай зөвшөөрлөөрөө энэ шар нутгаа хадгалж байгаа.

Тээвэрлэх юм уу, худалдах тусгай зөвшөөрөл нь олгогдоогүй. Одоо тэгээд худалдах юм уу, гадагшаа экспортлох чиглэлээр бол саналаа гаргаагүй байгаа. Тийм учраас бид нар энэ хөрөнгө оруулалтын гэрээний дараа хамтарсан компани нь ямар санал гаргахыг тэр үед нь бол Цөмийн комиссын хуралдаанаар шийдвэрлэнэ. Баярлалаа.

**Ц.Даваасүрэн:** 4 номерын микрофон Жавхлан сайд гүйцээе.

**Б.Жавхлан:** Гишүүдийн нийтлэг асуугаад байгаа асуултад би тайлбар хэлье гэж бодлоо. 34 хувь бид нар авч болох байсан хувь хэмжээ болон одоо авахаар хэлэлцээрт орсон өгөөж хоёрыг харьцуулж асуугаад байгаа юм. Яг эдийн засгийн агуулгаараа энэ 2 үзүүлэлтийг яг махан тоогоор нь хооронд нь харьцуулах боломжгүй 2 үзүүлэлт байхгүй юу. 34 гэдэг энэ эзэмших хувь хэмжээ, тэрнээс гарах өгөөж бол өөрөө тусдаа асуудал. Тэр өөрөө хувьсах үзүүлэлт байхгүй юу Оюу толгой дээр жишээ нь өнөөдөр бид нар хувь эзэмшээд өнөөдрийг хүртэл 1 центийн ч ногдол ашиг аваагүй байгаа.

Тэгэхээр 34 хувийг яах вэ, махчлаад 34 хувийн өгөөж авч болох юм гэж хараад нөгөө бид нарын хэлэлцээрт хийж чадсан өгөөжтэй нь харьцуулж гарах юм бол бид 51 хувийн өгөөжийг ямар ч тохиолдолд тогтвортойгоор авахаар ингэж зааснаараа өмнөх хөрөнгө оруулалтын.../минут дуусав./

**Ц.Даваасүрэн:** 4 номерын микрофон 1 минут нэмье.

**Б.Жавхлан:** Тийм. Тэгэхээр бид өмнөх алдаагаа давтаж болохгүй. Хэзээ ч магадгүй авч чадахгүй байх ноогдол ашгийн төлөө ийм хэлэлцээр хийгээд дахиж алдаа хийж болохгүй. Харин тэрний оронд бид нар өнөөдөр 51 хувийнхаа өгөөжийг авахаар цуглуулж байгаа өгөөжүүд, гол өгөөжүүд маань давуу эрхийн 10 хувь, суурь 5, тусгай 5, өсөн нэмэгдэх 9, аж ахуйн нэгжийн орлогын албан татвар гээд. Дээрээс нь 51 хувь хэрвээ дутвал өгөөжөө бид нар тэнцвэржүүлэхэд нэмэлт төлбөрөө авна. Ингээд 51 хувийг бид нар тогтвортой аваад явна гэдэг маань нөгөө хувьсах үзүүлэлт хэрвээ ашигтай ажиллавал, ноогдол ашиг авахаар бол 34 хувь гэдгээсээ илүү ямар эрсдэлгүйгээр энэ тоглоомд бид оролцож байна л гэсэн үг.

Тийм учраас энэ хоёрын агуулга, эдийн засгийн ойлголт нь бас арай өөр. Харьцуулж ярих юм бол ийм тайлбар байна гэж хэлэх гэсэн юм.

**Ц.Даваасүрэн:** Ганбаатар гишүүн асуулт асууя. Дутуу байгаа юм уу? Тодруулъя Номинчимэг гишүүн.

**О.Номинчимэг:** Нэгдүгээрт усны төлбөр дээр тооцооллоо хэлээд өгөөч. Усны төлбөр.

Хоёрдугаарт энэ нөгөө компанийн санхүүгийн байдал гээд. Энэ гэрээн дээр болохоор хүртэл, өдийг хүртэл энэ Францын компаниас Бадрах Энержид хувьцаа эзэмшигчдийн зээл өгчихсөн. Энэ зээлийг бол энэ гэрээ хэрэгжсэнээс хойш хувь нийлүүлсэн хөрөнгөд хөрвүүлнэ гээд тэгчихсэн байгаа тээ? Тэгэхээр энэ хэр хэр хэмжээ байгаа юм? Энэ компани маань Монгол Улс давуу эрхийн 10 хувийн хувьцаа эзэмших гэж байгаа энэ компани маань ямархуу санхүүгийн өөрийн хөрөнгө, хувьцаа эзэмшигчийн хөрөнгө нь ямархуу байгаа юм? Тэгээд хөрөнгө оруулалтын хэмжээнд та бүхний бас санхүүгийн нөгөө моделио гаргаж хийсэн гэж байна. Гэрээн дээр 1 тэрбум 650 сая доллар нийт өөрсдийнх нь орох хөрөнгө оруулалт гэсэн. Энэ маань өөрөө тэр энэ гэрээний хугацаа, төсөл хэрэгжих бүх шатад та бүхэн ер нь хангалттай байна гэж үзэж байгаа юу?

**Ц.Даваасүрэн:** Сүүлийнх нь асуултаас нь хариулъя. 2 номер уу? 2 номер, тэгээд дараа 9 номер хариулна шүү.

**Б.Хулан:** Ажлын хэсгийн гишүүн Хулан. Нямчимэг гишүүний асуултад нэмэлт тайлбар өгье.

Монгол Улс олон улсын олборлох салбарын ил тод байдлын санаачилгаар нэгдсэн орон. Хөрөнгө оруулагч талаас ирүүлсэн санал болон манайтай ийм ижил төстэй загвараар хөрөнгө оруулалт хийсэн Филиппин гэх мэт улсын туршлагыг харахад энэ ил тод байдлын санаачилгаар тайлагнаж байгаа бүх төрлийн татвар хураамж, шимтгэлийг тухайн улсын үр өгөөжид оруулж тооцно гэдэг саналыг цаад талаас ирүүлсэн.

Бидний зүгээс бол энийг илүү хязгаарлаж, хумьж, ингэж нэрлэж бид нар оруулна гэдэг саналаа тавьж, хүлээн зөвшөөрүүлж чадсан байгаа.

Ус ашигласны төлбөр, ус бохирдуулсан гэдэг нь 2 ялгаатай. Бохирдолтой холбоотой бүх тэр татвар хураамж, төлбөрийг бид нар өгөөжид оруулахгүй гэдэг байдлаар нөгөө талдаа хүлээн зөвшөөрүүлж чадсан. Ус ашигласны татвартай холбоотойгоор Монгол талын хүртэж байгаа үр өгөөжийг 100 хувь гээд хувилаад үзэх юм төслийн нийт хугацаанд ус ашигласны татвар нь 0.4 хувийг эзэлж байгаа. Энэ нь нийтдээ 23 сая доллар юм.

Төслийн хэрэгжих хугацаатай холбоотой бүтээн байгуулалтын үе шатыг 4 жил гэж тооцоолж байгаа. Олборлох, үйлдвэрлэл явуулах хугацааг 33 жил гэж тооцоолж байгаа. Хаалтын үйл ажиллагааг 10 жил гээд ингээд нийтдээ 47 жил гэж тооцоолж байгаа. Хөрөнгө оруулалтын тоо хэмжээний хувьд бол энэ ТЭЗҮ дээр тооцоолж бид нар санхүүгийн загвараа угсарсан байгаа. ТЭЗҮ дээр. Ирээдүйд болзошгүй ямар нэгэн өөрчлөлт ороход түүнийг дагаад санхүүгийн модель маань өөрчлөгдөөд явна. Хөрөнгө оруулалтын тухайд бол анхны хөрөнгө оруулалтыг заавал ч үгүй өөрийн хөрөнгөөр хийнэ гэдэг шалгуурыг оруулж ирчихсэн. Энэ нь юунаас сэргийлж байна вэ гэхээр бид нар ямар нэгэн санхүүжилтийн зардал, хувьцаа эзэмшигчдийн зээл гэдэг юм уу өөр байдлаар санхүүжүүлэхэд Монгол тал дээрх ноогдол ашиг хойшлох, хоцрох янз бүрийн асуудал үүсэхээс сэргийлэхийн тулд энэ дээр зарим нэгэн хориг тавих, эсвэл 100 хувийн хувьцаа эзэмшигчдийн саналаар шийднэ гэдэг гол гол заалтуудыг хөрөнгө оруулалтын гэрээн дээр оруулсан. Нарийн зохицуулалтыг хувь нийлүүлэгчдийн гэрээн дээр оруулахыг эрмэлзэж ингэж ажиллаж байгаа.

**3.Батбаяр:** Ус ашигласны төлбөрийн тухай асуудал дээр энэхүү гэрээн дээр зааснаар та бүхэн гэрээний 8.4 дээр усны тухай асуудлыг харж болно. Энэ дээр хамгийн том оновчтой зүйл нь усны асуудлыг тогтворжуулахгүй гэсэн үг буюу аливаа асуудал үүсэхэд тухайн цаг үед нь хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хууль тогтоомж, дүрэм журам зааврын дагуу явна гэсэн.

Сая манай зөвлөх бас хэллээ Монгол Улсад 4 янзын усны төлбөр байдаг. Ус ашигласны, усны нөөц ашигласны төлбөр, ус бохирдуулсны төлбөр, ус хомсдуулсны төлбөр, усны үйлчилгээний төлбөр гэж. Энэ гэрээн дээр 2 зүйл яригдана. Ус бохирдуулсны, ус ашигласны хоёулан дээр нь төлбөрийг авахаар тохирсон байгаа. Яг гишүүний асуулт ус ашигласны төлбөрийн тухай асуудал байгаа учраас ус ашигласны төлбөр дээр зөвхөн үйлдвэрлэлийн болон технологийн зориулалтаар ашигласан усан дээр яригдана. Галба-Өөш-Долоодын говь яг одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа 2013 оны Монгол Улсын Засгийн газрын тогтоол ёсоор байгаль орчны, усны экологи эдийн засгийн үнэлгээ нь Галба-Өөш-Долоодын говь дээр 4 мянга.../минут дуусав./

**Ц.Даваасүрэн:** 9 номерыг нэмээд өгчихье.

**3.Батбаяр:** 4400 төгрөг байгаа 1м<sup>3</sup> нь. Тэгэхээр итгэлцүүртэйгээрээ тооцоод ойролцоогоор л яг одоогийн үнээр тооцох юм 1 литр нь 1-2 төгрөгийн үнэтэй гэж тооцож болно. Энэ ТЭЗҮ дээр бичсэнээр энэхүү төсөл дээр хэрэглэх усны хэмжээ 17 литр секунд байх юм.

Тэгэхээр тэр хэмжээний төлбөрийг авна гэсэн үг. Эндээс хасагдах нь ус дахин ашигласан тохиолдолд хуулийнхаа дагуу ус хасагдана. Ус бохирдуулсны

төлбөр бол байгальд нийлүүлсэн бохир усны найрлагаас нь хамаараад ингээд явчихна. Яаж ажилладаг вэ гэхээр Усны газраас усны асуудал эрхэлсэн Засгийн газрын эрх бүхий байгууллагаас жил болгон, улирал болгон ус бохирдуулсны төлбөрийг, жил болгон ус ашигласны төлбөрийг тодорхойлсон дүгнэлт гаргаад явдаг учраас урдах жилүүдийн тайлан дээр нь үндэслээд дараа жилийн тайланг нь гаргаад явчихна. Ер нь цаашдаа бидний барьж байгаа бодлого бол усны үнэлэмжийг нэмэгдүүлэх зорилгоор үнийг нэмэх боломжтой гэж үзэж байгаа. Энэ боломжоо энэ гэрээн дээрээ аваад хадгалж авч үлдэж чадсан гэж.

**Ц.Даваасүрэн:** Ганбаатар гишүүн асуултаа асууя.

**С.Ганбаатар:** Энэ Үндсэн хуулийн 6-д заасныг би бас сануулчихъя. Газрын хэвлийн баялаг “гагцхүү” гэж үг байгаа юм шүү. “Гагцхүү ард түмний мэдэлд” гэж байгаа. Тэгээд ард түмнээс мандат аваад энэ тал дээр ард иргэдийн баялгаар наймаа хийх эрх нь Улсын Их Хурлын гишүүдэд байгаа. Одоо энэ эрхээ та нарт өгөх гээд олон зүйл асууж байгаа. Ялархаж болохгүй. Энэ дээр мэдээж та нар сэтгэл гаргаж ажилласан байгаа. Ямар ч байсан тэр хөрөнгө оруулалтын гэрээний энэ явц хэрэгжилт дээр бид хатуу хяналттай байна. Энэ ард иргэдийн Үндсэн хуулиа бид хэрэгжүүлнэ. Энэ дээр хичээж ажиллаж байгааг мэдэж байгаа. Тэгэхдээ асуух зүйлүүд байна.

Нэгдүгээр асуух зүйл бол шууд асуултдаа орьё. Энэ үйл ажиллагааны зардал, хөрөнгийн зардал 4 хувь байна. Маркетингийн зардал, худалдаа борлуулалтын зардал 2 хувь байна гэж байгаа. Энэ ерөөсөө бидний ашигт ерөөсөө нөлөөлөхгүй юу гэдэг асуултад шууд хариулж өгөөч. Ямар ч нөлөө байхгүй. Тэднүүс зардлаа дураараа нэмэх нүхийг нь нээж өгчхөөд байхад манай ашигт ямар ч нөлөөлөхгүй гэж л түрүүнээс хойш яриад байна. Ямар зүйлээр яаж ойлгох вэ? Энийг энэ дээр манай ашигт нөлөөлөхгүй гэдгийг тайлбарлаж өгөөрэй. Энийг эсэргүүцэж байгаа. Ингэж дээрэлхүүлж болохгүй. Оюу толгой дээр ч. Энэ чинь технологио тэд өөрсдөө үйлдвэрлэж байгаа шүү дээ. Францын ард түмнийг бид өнөөдөр ногоон хямд эрчим хүчээр хангах гэж энэ шар нунтгаа өгөх гэж байгаа. Бид уран олборлож ураны реактор бид ажиллуулах гээгүй шүү дээ. Тэд технологио ашиглана. Тэд өөрөө өөртөө маркетинг хийх гэж байгаа юм уу? Та нар энэ өгүүлбэрийг хар даа. Хувьцаа эзэмшигчийн худалдан авагчийн хувиар авсан бүтээгдэхүүнийг цаас борлуулах нөхцөлийг бий болгох зорилготой. Өөрөө өөртөө 2 хувиар хямдхан авч байна гэдгийг л зааж байна шүү дээ. Энэ дээр манай ашигт нөлөөлөхгүй юу? Хариулт авъя.

Хоёрдугаар зүйл миний асуулт, та нар энэ гэрээний заалтад оруулаад ирчихсэн байна Засгийн газар нь бүтээгдэхүүний 10 хүртэл хувийг хөрөнгө оруулагчтай ижил нөхцөл, болзлын дагуу худалдан авахаар гэрээний төсөлд тусгалаа гэж байгаа юм. Үгүй энэ чинь 34 хувийг нь огт үнэ төлбөргүйгээр ямар ч санхүүгийн эрсдэл үзэхгүйгээр газрын доорх баялгаа бид өгч байгаа. Тэрүүгээрээ үнэлж, 34 хувиа ямар ч үнэ төлбөргүйгээр авна гэж байгаа шүү дээ. Үнэ төлбөргүй гэдэг үг буруу л даа. Баялгаа өгөөд авч байгаа. Одоо тэгсэн дээр нь, энэ дээр энэ та нар хараарай хөрөнгө оруулагчтай ижил нөхцөл, болзлын дагуу худалдан авахаар гэрээний төсөлд тусгалаа гэж үг байгаа. Дээрээсээ 4 дэх мөр шүү. Энийг надад тайлбарлаж өгөөч.

Дараагийн асуулт маркетингийн төлбөрийг татварын болон санхүүгийн тайлангийн зорилгоор хасагдах зардал дээр бүртгэхгүй болохыг хэлэлцээрийн явцад хөрөнгө оруулагч талаар зөвшөөрүүлэв. Яг нөгөө зардал юу 2 бүүр энэ дээр

ингээд баталгаажуулсан. Татвар ноогдохгүй гэж байгаа юм. Үгүй би энийгээ надад тайлбарлаж өгөөч. Дараад нь би бас асуулт асууя, тодруулга авна.

**Ц.Даваасүрэн:** Тэр энэний өмнөх хуралдаан дээр нөгөө менежментийн Пи Би юу төлбөр бий юу гэсэн чинь та бүхэн нөгөө байхгүй гэж хариулаад байсан байхгүй юу. Тэгсэн чинь одоо энэ гэрээн дээр харахаар Оюу толгой чинь зардлаас 6 хувийг авч байгаа шүү дээ. Гэтэл энэ чинь маркетингийн төлбөр нэрээр борлуулалтаас 2 хувь, ноу хауны төлбөр гээд зардлаас 4 хувь, энэ чинь ОТ-гоос давчихсан байгаа байхгүй юу. Тэгээд эртээд болохоор үгүй ээ гээд надад ингээд хэлчхэж байгаа юм. Тэгээд би итгээд сайн болж гээд ингээд байдаг. Гэтэл зардлаас 6 хувь авахаас илүү төлбөр төлөхөөр юм хийчихсэн байгаа байхгүй юу. Тэгээд Ганбаатар гишүүн тэрийг асуугаад байна шүү дээ. Тэгээд энэ чинь эд нар ийм л юм аваад л байвал бидний ашиг буураад л байна гэсэн үг шүү дээ.

4 номерын микрофон.

**Б.Жавхлан:** Ганбаатар гишүүний асуултад хариулъя.

Би яг таны асуултыг бүтэн сонсоогүй ороод хоцорчихсон шүү. Уучлаарай би ерөнхий ер нь ойлголт авчихлаа. Тэгэхээр ийм юм байгаа юм. Оюутолгойтой л харьцуулж хэдүүлээ ярья. Тэгж байж их ойлгомжтой болж ирнэ. Оюутолгойн хувьд бид нарын сул орхигдсон зүйл юу вэ гэхээр тэрийг нь өгөөжид нь тооцохгүйгээр яг зардалд нь ингээд үлдээчихсэн байхгүй юу. Тэгэхээр хэмжээ, хязгааргүй тэрийг өсгөх замаар цаанаа өөрсдөө ингээд далд өгөөж авах ийм боломжийг нь ингээд сул орхичихсон. Энэ удаагийн гэрээн дээрээ бид нар энийг яаж хязгаарлах хөшүүрэг оруулсан бэ гэхээр энийг нь өгөөжид нь тооцчихсон. Энэ чинь та нарын өгөөж шүү гээд албан ёсоор. Өөрөөр хэлбэл нөгөө 49 хувийнхыг нь өгөөжид нь оруулчхаж байгаа юм. Ингэхээр хэмжээ хязгааргүй өсгөж чадахгүй. Өөрөөр хэлбэл, 49-дөө багтаагаад өгөөжөө өсгөлөө гэхэд энэ зардлаараа манай 51 хувь дагаад өснө.

Өөрөөр хэлбэл, нөгөө тэнцвэржүүлэх 51-д төлөх ёстой төлбөр маань, бид нарын авах төлбөр маань яг тэрийг дагаад нэмэгдээд явчихна гэсэн үг. Тэгэхээр үүгээрээ хязгаарлагдчихаж байгаа байхгүй юу. Өсгөх хэмжээ маань. Тэгэхээр тэр 6 байна уу, 10 байна уу бид нар тэрийг өсгөсөн ч бид нарын 51 хувь дээр ашигтай, одоогийнхоороо тогтмол зардал дээрээ өсгөхгүй байж байсан ч бид нарт хэрэгтэй ийм л болчхож байгаа юм.

Тэгэхээр өмнөх хөрөнгө оруулалтын гэрээнүүдээс нэг давуу тал бөгөөд сая хэлэлцээрийн шатанд би энэ залуучуудаараа үнэхээр бас бахархаж байна. Нэг үеэ бодвол манайх үнэхээр энэ цаад талын улсуудтай яг энэ зэрэгцэх хэмжээний ийм үндэстний мэргэжилтэн, экспертүүдийг бид нар энэ хугацаанд бэлдэж чадсан байна. Тийм учраас энэ яг энэ зардал дээр бид өөрийнхөө ёстой талдаа ямар ч тохиолдолд үр өгөөжтэй ашигтай байхаар ингэж хийж чадсан гэдгийг бүр хариуцлагатайгаар хэлж чадах байна.

**Ц.Даваасүрэн:** Юу билээ хоёр дахь нь? Үгүй ээ энэ чинь байна шүү дээ ялгаа байхгүй юм байна лээ Жавхлан гишүүн ээ. Зардлаас байхгүй юу. Зардлаас 4 хувь, Оюу толгой зардлаас 6 хувь байхгүй юу. Ялгаа байхгүй бүүр аюултай нь байна шүү дээ борлуулалтаас 2 хувь байгаа байхгүй юу. Энэ чинь л авчхаж байгаа байхгүй юу. Зардал, борлуулалт хоёрын борлуулалт нь их шүү дээ. За яах вэ Оюу толгой ашиггүй ажиллаад зардлаа илүү гаргачихдаг байх. Тэгэхээр энэ дээр нэг

юм харагдаад байна шүү дээ. Ганбаатар гишүүний хэлээд байгаа үнэн байхгүй юу. Зардлаас 4 хувь та нарыг ноу хау гээд ав гэж байгаа чинь та нар зардлаа өсгөөд яв л гэсэн үг л дээ. Яах вэ өөрөө ингээд манай хувийг өсчих вий гэж айгаад барих байх, үгүй барихгүй. Бид бас л хянаж чадахгүй шүү дээ. Тийм учраас, ер нь айлын тал яах ёстой вэ гэвэл ашигтай ажиллуулж байж тэнд төлбөр авна уу гэхээс биш зардал өсгөхөөд төлбөр авдаг байж болохгүй шүү дээ.

Ганбаатар гишүүний тэр хоёр дахь асуултыг нь бас хариулна шүү.

3 номер.

**Б.Тэлмүүн: Нэгдүгээрт, Сангийн яам Тэлмүүн.**

Яг гишүүдийн энэ асууж байгаа асуулт бол хэлэлцээрийн бид нарын шийдэхийг зорьсон хамгийн гол асуудал байсан.

Нэгдүгээрт, маркетингийн төлбөрийн хувьд маркетингийн төлбөр бол төслөөс мөнгөн хөрөнгийн урсгалаар гарахгүй. Энэ бол.../минут дуусав./

**Ц.Даваасүрэн:** Борлуулалтын 2 хувь л гэж байгаа шүү дээ. 2 номерын микрофоныг өгчих. 2 номерыг дахиад өг.

**Б.Тэлмүүн:** Маркетингийн төлбөр бол бүтээгдэхүүний борлуулах, үнэ тооцоход ашиглагдаж байгаа. Тэрнээс төслийн үйл ажиллагаанаас яг мөнгөн хөрөнгийн зардлаар буюу каш флов/cash flow/ урсгалаас ингэж хасагдаж гарахгүй. Тэгсэн ч гэсэн бид маркетингийн төлбөр болон ноу хау-ын төлбөрийг айлын талын өгөөжид оруулна гэсэн үг. Тэгэхээр нэгдүгээрт мөнгөн хувьд бол.

**Ц.Даваасүрэн: Оюу толгой** ч гэсэн орж байгаа. Тэд нарын өгөөж болж очиж байгаа. Тэр 6 хувь чинь очиж байгаа. Тэд нарын л өгөөж шүү дээ. Тэр чинь 6 хувийг тэгээд л менежментийн төлбөрөө л авч байгаа шүү дээ. Тэд нарын өгөөж л байхгүй юу.

**Б.Тэлмүүн:** Хариултаа дуусгачхаж болох болов уу?

**Ц.Даваасүрэн:** Би удирдаж байгаагийн хувьд зохицуулчихъя. Чи удирдах юм уу? 3 номер. Чамайг би худлаа ярьж болохгүй гээд байна шүү дээ. Борлуулалтын 2 хувь л гэж байна шүү дээ. За хариул маяглаад байх юм зүгээр.

**Б.Тэлмүүн:** Маркетингийн төлбөрийн хувьд бол төслийн үйл ажиллагааны зардал, өртөгт орохгүй. Энэ бол дэлхийн зах зээл дээр байгаа эцсийн спот түүнээс борлуулалтын гэрээ хийхдээ хасагдаж тооцох үнэлгээ байгаа. Тэгсэн хэдий ч энэ төслөөс каш флов/cash flow/ мөнгөн урсгалаар гарахгүй ч гэсэн бид хэлэлцээрийн явцад айлын талын өгөөж тооцсон байгаа. Маркетингийн төлбөр яаж бодогдох вэ гэдэг нь хөрөнгө оруулалтын гэрээн дээр тодорхой тусгачихсан.

Хоёрдугаарт нь маркетингийн төлбөрийн хувьд айлын талын хүртэх өгөөжид ер нь хэдий хэмжээний дүн эзлээд байгааг бид нар харах ёстой. Санхүүгийн тооцооллоос үзэхэд Орано талын нийт 4.9 тэрбум долларын өгөөж хүртэхээс маркетингийн төлбөр ердөө 5.8 хувь байгаа. Энэ төлбөр нэмэгдэх тусам айлын талын өгөөж өснө. Энэ хэрээр Монголын талын 51 өгөөж давхар өснө. Тэгэхээр 2



талдаа өгөөжид нь ингэж давхар өсөх учраас айлын талаас энэ зардлуудыг өсгөж тооцох ийм сонирхол бага байна.

Та Оюу Оюу толгойн хөрөнгө оруулалтын гэрээтэй харьцуулж ярьж байна. Оюутолгойн хөрөнгө оруулалтын гэрээний хувьд хамгийн том зардлыг шууд бусаар өгөөж хэлбэрээр хүртдэг бол зээлийн хүүгийн, хувь нийлүүлэгчийн зээлийн хүү, маркетинг, менежментийн төлбөр 2 байгаа. Хувь нийлүүлэгчийн зээлийг бид зөвшөөрөөгүй. Энэ дээр огт байхгүй. Зөвхөн өөрийн хөрөнгөөр санхүүжүүлнэ гэсэн. Нөгү хау төлбөрийн хувьд дэлхийн зах зээл дээр зарагддаг энэ ураны ислийн хамгийн сүүлийн технологийг кальцинатжуулах технологийг Орано өөрөө эзэмшдэг. Энэ ноу хау технологийг Монгол Улсад үйл ажиллагаанд нь оруулж байгаа гэдэгтэй холбоотойгоор энэ зардал гарна. Энэ бол зардал ноу хау-ын төлбөр айлын талын хүртэх өгөөжийн ердөө 3.6 хувь байгаа. Хэрвээ зардал нэмэгдээд энэ ноу хау-ын төлбөр өсөх юм бол манай талын хүртэх өгөөж дагаад өснө.

**Ц.Даваасүрэн:** Тодруулах юм уу, болчихсон уу? Жавхлан сайд 4.

**Б.Жавхлан:** Би нэмж хариулъя. Одоо яг энэ маркетингийн зардлыг өгөөжгүй биш үү гэдэг дээр бүгдээрээ бид тал болов уу л гэж ингэж найдаж байна. Оюу толгой дээр гэрээн дээрээ албан ёсоор тэр маркетингийн зардлыг зардалдаа шингээгээд цаанаа бид нар өгөөж болгож авна гэж оруулаагүй байхгүй юу. Гэрээн дээр нь тийм юм байхгүй.

Гэтэл бодит байдал дээр бол энэ зардлаа өсгөөд, тэнд өгөөж аваад байгаа нь бол бодитой үнэн. Хэрвээ бид нар тэр Оюутолгойн гэрээн дээр энэ танай өгөөж шүү гээд албан ёсоор оруулчихсан байсан бол энэ одоогоор маргахгүй байх байсан. Харин тэгвэл бид нар энэ удаагийн энэ Ораногийн гэрээн дээр энийг албан ёсоор танай өгөөж шүү гэдгийг хүлээн зөвшөөрүүлж чадсанаараа л онцлог байгаа юм. Өөрөөр хэлбэл, 49 хувь, юуных чинь өгөөжийн тэр 49 хувьд чинь энэ чинь орж байгаа шүү гээд албан ёсоор зөвшөөрүүлчхэж байгаа юм.

Тэгэхээр манай 51 хувь яг энэнтэйгээ параллельно манайд төлбөр тэр хэмжээгээр нэмэгдэнэ. гэсэн үг. Нөгөө 51 хувиа гүйцээж авах.

**Ц.Даваасүрэн:** Тэр 10 хувийг нь хариулъя. Тэр Оюу толгой ч гэлээ гэсэн яг энэ хөрөнгө оруулалтын гэрээний асуудлыг оруулж ирж байхад тэр манай өгөөж дээрх 54 хувь гэдэг дээр чинь тэр миний, манайх юмнуудыг ноогдол ашиг энэ тэрийг тооцоод, өөрийнхөө талд болохоор тэр менежментийнхээ 6 хувиа оруулаад тооцсон тийм загварыг л бид нар танилцуулсан байхгүй юу. Тэгэхдээ бид нар өнөөдөр 54 хувиа хүртэж байна уу, үгүй юү бүү мэд. Яах вэ та нар өөрсдөө тэр тэр үед гишүүн биш байсан болохоор мэдэхгүй байгаа байгаа. Яг тэгж танилцуулсан байхгүй юу. Манай өгөөж бол энэ гээд.

Тэр 10 хувийг нь хариулъя. Юуны гэлээ? Худалдаж авахтай холбогдолтой хэн хариулах юм? Адилхан нөхцөлөөр гээд байгаа юм байна. 2 номер.

**Б.Хулан:** Ажлын хэсгийн гишүүн Хулан Ганбаатар гишүүний асуултад нэмэлтээр хариулъя.

10 хувийн бүтээгдэхүүн худалдаж авахтай холбоотой таны асуултыг хоёр тал ижил нөхцөлөөр яаж худалдаж авах вэ гэж асууж байх шиг байна. Тэгэхээр бид нар борлуулалтын үнэ гэдэг зүйлийг гэрээнд оруулж өгсөн.

Өөрөөр хэлбэл, хөрөнгө оруулагч тал үнийг гэрээн дээр өөр байдлаар тогтоох замаар яаж болохгүй. Бид нар ямар их тэр хоёр баталгаатай үнэ хэвлэдэг тэр биржийн сүүлийн 6-н долоо хоногийн дундаж үнээр үнэ тогтооно. Монгол тал 10 хувийн бүтээгдэхүүнээ авахдаа ижил нөхцөлөөр байна. Саяын яригдаж байгаа маркетингийн фидик гэдэг энэ ойлголтыг Монгол тал бүтээгдэхүүн дээрээ бас тооцож авна гэдэг агуулгыг оруулсан байгаа. Түрүүний нөгөө үр өгөөжийн тооцооллын асуудал дээр болохоороо 51, 49, 51-ээс багагүй байна гэдэг тооцооллын чинь техник талаасаа хүртвэр дээр нь Монгол талын өгөөж явж байгаа. Хуваарь дээр нь хоёр талын өгөөжийн нийлбэр.../минут дуусав./

**Ц.Даваасүрэн:** 2 номерыг дахиад 1 минутаар сунгая. 2 хариулья.

**Б.Хулан:** Тэгэхээр үр өгөөж тооцох тэр томъёоны хүртвэр дээр нь Монгол талын хүртэх үр өгөөжийн хуримтлагдсан дүн, хуваарь дээр нь Монгол талын болон хөрөнгө оруулагчийн хүртэх үр өгөөжийн нийлбэрээс анхны хөрөнгө оруулалтыг хасаж байгаа. Тэгэхээр энэ хувиар томроод ирэхийн хэрээр буюу та бүхний хэлж байгаа маркетинг пий, нөү хау пий ноогдол ашиг нэмэгдэхийн хэрээр хэрвээ Монгол талын үр өгөөж 51-ээс доошоо орох тохиолдолд нөгөө талд тохируулах төлбөр төлөхийг үүрэг хүлээхээр энэ гэрээнд оруулж өгснөөрөө их давуу талтай. Бусад улс оронд ижил төстэй гэрээ хийснийг бид нар бас нээлттэй байгаа хэмжээнд нь хууль, эрх зүйн хүрээнд нь харж үзсэн. Филиппин, Эквадор, Танзани, Нигер гэх мэтчилэн. Тэгэхээр энэ үр өгөөжийн тохируулга гэдгийг бол улс орнууд тухай төдийлөн бас оруулж чадаагүй байдаг нь сул тал болдог юм байна лээ. Энэ гэрээний гол онцлог, давуу тал нь ямар нэгэн байдлаар энэ 51 хувиас доош орох тохиолдолд энийгээ гүйцээж нөхөж авна гэдэг нь бас их том онцлог болж байгаа юм гэдгийг бас хэлье.

**Ц.Даваасүрэн:** Болсон уу? Айн? 5 номер Учрал сайд.

**Н.Учрал:** Тэгээд ер нь энэ хөрөнгө оруулалтын гэрээг хийх хэлэлцээний явцад энэ өгөөжийн тохируулгыг хийсэн нь нэг сайн давуу тал болсон. Олон улсын тэр “Си Ар Эй” ч гэсэн яг үнэхээр энэ нөү хау-тай холбоотой зардлыг зардалд бүртгээгүй, хөрөнгө оруулагч талын өгөөжид бүртгэсэн чинь Засгийн газрын хувьд ялалт байсан гээд ингээд сүүлийн зөвлөмж өгөөд байгаа юм.

Яагаад гэхээр Оюу толгой дээр болохоор ийм цоож байгаагүй. Оюу толгой дээр тэр 51-ийн нөгөө өгөөжийн тохируулга хийх цоож байгаагүй. Тэгээд бид нар энэ нэгэнт нөгөө санхүүгийн модель нь байхгүй учраас тооцоолол хийхээр Оюутолгойн гэрээн дээр хэрвээ ийм өгөөжийн тохируулгыг хийчихсэн байсан бол 10-23 онд бол нэмэлтээр 352 сая долларыг жилд авах бол ийм тооцооллыг бид нар гаргаж бас үзсэн. Дээрээс нь түрүүн нөгөө 34 авах, авахгүй гээд яриад байна. Зарим нь бараг 34-өө авбал зөв байсан юм уу ч гэдэг юм нийгмийн ийм хэлэлцүүлэг болж байна. Тэгээд ингээд аваад үзэхээр үнэндээ Оюу толгой тухайн үед Засгийн газарт орох мөнгөн урсгал гээд энэ танилцуулж байхдаа ийм хүснэгт гаргаж байсан нь.../минут дуусав./

**Ц.Даваасүрэн:** Сунгах юм уу? 5 номерыг сунгая.

**Н.Учрал:** Оюутолгойн төслөөс Монгол Улсын Засгийн газарт орох мөнгөн урсгал гээд энэ танилцуулж байсан хүснэгт байна л даа. Эндээс харахаар ноогдол ашиг нь бараг 20 хувийг эзэлж байсан байх. 20 хувийг л ноогдол ашгийг бид нар аваагүй л байна шүү дээ. Нэг ёсондоо бол зардал дотор нь ноу хау, маркетинг, менежментийн зардлыг биччихсэн учраас зардал нь нэмэгдээд, ашиг нь улам хойшлоод сүүлдээ 34 хувь дээрээ одоо бид нар чинь олон улсын шүүх дээр л энэ арбитр дээр л явж байгаа байхгүй юу.

Тэгэхээр ер нь бол бид нар ингэж санхүүгийн хариуцлага хүлээх нь бол боломжгүй. Харин АМНАТ-аар хэрвээ орлуулсан бол гээд Оюу толгой төсөл дээр 10-23 онд АМНАТ-аар орлуулсан бол, зөвхөн 5 хувиар орлуулсан бол 807 сая доллар ингээд өсөх ёстой, боломжтой байсан жилд. АМНАТ-аар зөвхөн орлуулсан бол. Хэрвээ бид нар тэр үед 34 хувийн ашиг, түүний 34 хувиа аваад, 20 хувийн ноогдол ашгийг хүлээж суугаагүй бол ийм боломж бол байсан. 2023-2050 онд төлөх АМНАТ гээд ингээд бодоод үзэх юм бол энэ нь өсөн нэмэгдэх АМНАТ-ыг тооцох юм бол бүүр 14 тэрбум, 5 хувиар бодох юм бол 4 тэрбум долларт хүрэх бололцоо бололцоо бол эндээс харагдаж байгаа. Яах вэ Оюутолгойн гэрээний тэр санхүүгийн модель байхгүй. Гэхдээ энэ Засгийн газрын зүгээс тухайн үед Их Хуралд танилцуулж байсан энэ мөнгөн урсгалын хүснэгт энэ тэрийг нь харахад.

Тэгэхээр Оюу толгой дээр бид нар 20 хувийн ноогдол ашиг авна гээд энд чинь аягүй өөдрөгөөр төсөөлчихсэн байж байгаа байхгүй юу. 2.8 тэрбум доллар л одоогийн байдлаар Оюутолгойгоос бүх төлбөр, татвараа бид нар аваад байна шүү дээ 23 оны бодит гүйцэтгэлээр. Гэтэл 2010 оны ТЭЗҮ-гийн тооцоолол чинь 6.2 тэрбум доллар байсан юм байна лээ шүү дээ. 6.2. Нэг ч ноогдол ашиг аваагүй. Тэгээд дахиад 34 аваад суух юм бол манайхан ямар байдалтай байх вэ? Харин энэ ажлын хэсэг энэ санхүүгийн мэргэжлийн энэ экспертүүд, энэ мэргэжлийн манай энэ ажлын хэсгийнхэн хөрөнгө оруулагчдын өгөөжид тооцоод зардал бүртгэхгүй 51-ийг чинь цоожлоод өгчихсэн. Хэрвээ үнэхээр өсгөөд яваад байх юм бол өгөөжийн тохируулгаа нэмээд явахаар Засгийн газарт ашигтай л гарна шүү дээ.

**Ц.Даваасүрэн:** Тэр заалтыг нь хэл, Учрал сайд аа бас энэ чинь иргэд үзэж байгаа. Яг цоожоо жишээлбэл. Наадах чинь их зөв зүйл сонсогдоод байгаа байхгүй юу цоож. Яг цоожилсон гэдгээ ингээд яг энэ гэрээний үүгээр ингээд гэдгээ хэлчих, уншаад өгчих. Тэгэхгүй бол Оюутолгойн гэрээг батлах ч гэсэн ёстой гоё бараг л өдөрт сая доллар орно энэ тэр гээд л байсан байхгүй юу. Тэгээд одоо тийм юм байхгүй шүү дээ. Тэгэхээр бас энэ ТЭЗҮ энэ тэр байхгүй учраас гишүүд наадхыг чинь баталгаажуулъя гээд байгаа нь зөв байхгүй юу. Яг гэрээний тэдний тэд дээр бид нар ийм цоож хийсэн гэдгээ уншаад өгчих.

**Н.Учрал:** Тийм, Ер нь Ганбаатар гишүүн, Даваасүрэн гишүүн энэ Оюутолгойн гэрээн дээр шүүмжлэлтэй хандаад байдаг нь аргагүй юм байна гэдгийг би бас энэ Засгийн газарт ороод ажиллаад ойлгож байна л даа.

Тийм учраас нөгөө өмнөх сургамжийг дахиж давтахгүйн тулд та нар 51 байлгана шүү л гэдэг ийм л зарчмыг би барьсан. Тэрнээс биш би их ус мэддэг, физик мэддэг болоод байгаа юу даа биш. Гол нь бол 51 байх ёстой л гээд. Тэгэхдээ та нар үндэслэлтэй гарга л гэнэ. Тэгээд энэ өгөөж тохируулах төлбөр гээд тэр бенефит эджастмент фи/benefit adjustment fee/ гэж нэрлэдэг юм байна. Түүнийг 4.1.С дээр хэрэв тухайн жилд гэрээний 4.1.А-д заасан Засгийн газрын төслөөс хүртэх шууд үр өгөөж хангагдаагүй тохиолдолд төсөл хэрэгжүүлэгч

компани нь Засгийн газрын төслөөс хүртэл шууд үр өгөөжийг төслийн нийт шууд үр өгөөжийн 51 хувьд хүргэхэд шаардлагатай нэмэлт төлбөрийг Засгийн газарт нөхөн төлөх үүрэгтэй гээд ингээд заагаад өгчхөж байгаа.

Тэгээд үнэхээр тэр нөгөө нөү хау-ын чинь зардал дээр бүртгэгдээгүй учраас тэд нар нэмэхэд хүндрэлтэй. Нэмээд яваад байх юм бол нөгөө манай дээр давхар өсөөд явчих байхгүй юу. 51 дээр өгөх өгөөжийн тохируулгын төлбөр нэмэгдээд явна л гэсэн үг. Тэгэхээр яг ижил. Нэг талд нь байна гэж байхгүй шүү дээ. 49, 51 гэлээ гэхэд адилхан ингээд өсөөд явна. Хэрвээ тэр тал нэмээд яваад байвал бид ч гэсэн өгөөжийн тохируулгаа нэмээд л авна. 51 авахгүй бол тэр гэрээ энэ чинь зөрчигдөж байгаа л асуудал үүсэх байхгүй юу.

**Ц.Даваасүрэн:** 41-ийн Б дээр тэр нөгөө юу 51 хувьд хүрэх нөхөн төлөх үүргийг хүлээнэ гэж байгаа заалтыг хэлээд байгаа тийм биз дээ? Тийм. Энэ бас нэлээн чухал юм болсон байгаа юм. Хэрвээ 51-д хүрэхгүй гэж үзэх юм бол заавал нөхөн төлөх үүргийг Францын төл. Энэ зөв. Хэд хэдэн сайн юм байгаа. Жишээлбэл, борлуулалтын орлогын 50 хувиа Монголын арилжааны банкаар дамжуулна. Энэ зөв. Тэр Оюу толгой бол зээл төлдөг компани болгоод хаячихсан байгаа. Өнөөдөр 17.8 тэрбум долларын зээл. Монголын нийт гадаад зээлийн 50 хувь. Өөрөөр хэлбэл, 60 тэрбум, 60 их наяд төгрөгийн өртэй компани болчихсон байгаа байхгүй юу. Тэгэхээр Оюу толгой үлдсэн хугацаанд юу хийх вэ? Зөвхөн зээл төлнө. Энэ 60 их наядын зээлийг төлнө. Тийм учраас харин энэ энэ гэрээн дээр ашигтай юм орсон нь бол тэр зээл авахыг нэлээн хаах гэж оролдсон байна лээ.

Тэгэхдээ энийгээ хэрэгжүүлэхийн төлөө л бид байх ёстой. Тэр Ганбаатар гишүүний хэлээд байгаа тэр адил тэгш 10 гээд байгаа нь тэр Монголын тал станц байгуулбал уран авахыг хэлээд байна уу? Хариулъя даа. 2 номер уг нь хариулаад байсан. Дутуу байна уу? 7. 6 юм уу? 6.

**С.Наранцогт:** Ер нь гэрээний энэ 10 хувийн бүтээгдэхүүнийг бол тэр нөгөө бичилтээс нь хамаараад янз бүрийн байдлаар тайлбарлаад байгаа байх шиг байна. Агуулгын хувьд ер нь яг бид нар өөрийнхөө нийт борлуулсан бүтээгдэхүүний 10 хувийг авах ийм эрхтэй. Өөрсдөө шууд авах эрхтэй л гэсэн үг. Тэгээд энийг бид нар бас энэ нөгөө цаашдаа бид нар бас Монгол Улс энэ цөмийн эрчим хүч ашиглаад явбал ер нь яах юм гээд ингээд бас тооцоо хийж үзсэн юм. тухайн үедээ. Энэ маань бидэнд ер нь хэр хангалттай дүн бэ гээд. Тэгээд жилд 2500 тонн энэ нунтаг бид нар энэ ураны исэл экспортлох юм шүү дээ. Ингээд 250 тонн 10 хувь чинь. Тэгээд манай Монгол Улсын ингээд яг эрчим хүчний хэрэглээнд хэд ордог юм бэ гэхээр жилд 581кг уран л яг хэрэглэгдэх юм билээ. Өөрөөр хэлбэл, энэ эндээс ингээд харьцуулах юм бол.../минут дуусав./

**Ц.Даваасүрэн:** 6 номерын микрофоныг дахиад сунгая.

**С.Наранцогт:** Ганбаатар гишүүн бол ингээд бид цаашдаа ингээд өөрсдөө ногоон эрчим хүчтэй болоод, цөмийн эрчим хүчтэй болохоор ингээд уран өөрсдөө урангүй болчих юм биш үү гэдэг юмыг өмнөх бас хэлэлцүүлгээр санаа нь зовоод байх шиг байсан. Тэгээд бид нар энэ дээр бас энэ олон улсын эх сурвалжуудыг үзээд нэлээн бас ажиллаж үзсэн. Тэгээд яг манай өнөөдөр Монгол Улсын яг өнөөдрийн цахилгааны хэрэглээг бүгдийг нь ингээд цөмийн эрчим хүчээр хангана гэвэл жилд бид нарт 581.3кг U3O2 хэрэглэгдэх юм байна лээ.

Гэтэл бид нар яг энэ гэрээгээр авах эрх маань бид нар 250 тонныг авах эрхтэй байгаа байхгүй юу. Тэгэхээр энэ бол энэнээс ингээд л харахад бид нар энэ өөрсдийн хэрэгцээнээсээ хэд дахин илүү бүтээгдэхүүнийг авна. Өөрөөр хэлбэл, бид өөрсдөө экспортлох, хэд дахин хэрэгцээнээс илүү экспортлох ийм боломжтой л гэсэн үг.

**Ц.Даваасүрэн:** Тодруулъя Ганбаатар гишүүн.

**С.Ганбаатар:** Бид би ч Оюутолгойдоо их баярлаж байгаа шүү дээ. Тэгээд ухаан ортол биднийг хулхидсан байна даа. 640 тэрбум долларын алт, зэсээр бид үнэгүй уул уурхайн курст суучихсан даа. Бас нэг юм яриад, ингээд бас ингээд ярьдаг болчихсон байна шүү дээ. Тэгэхлээр бас Оюутолгойд баярлах юм бий шүү. Ухаан ортол хусуулчихсан бид нар чинь. Тэгээд миний асуултад хариулахгүй байна л даа. Ядаж байхад цаг нь их хурдан явах юм. Энэ анх орж ирэхдээ энэ Цөмийн энергийн тухай хуулийн 5.2, 5.3 дээр чинь 51 хувь, 34 хувийг баялгаараа дүйцүүлээд огт үнэ төлбөргүйгээр авна гэсэн. Энэ дээр эзэмшинэ гэж байгаа шүү. Бүр авна, эзэмшинэ. Тэгсэн чинь энэ дээр 10 хувийг хөрөнгө оруулалтын эрхтэй ижилхнээр болзолтойгоор худалдаж авна гээд үг орчихсон байна. Үүнийгээ тайлбарлаач гэсэн бүр ингээд далийгаад явчих юм. Нэгдүгээр асуулт.

Хоёрдугаар асуулт, хөөш ТЭЗҮ байхгүйгээр ингэж татаа тунгаагдаж ингэж гэрээ байгуулна гэж энэ чинь хууль зөрчиж байгаа юм шүү дээ бид. Предмет судлагдахуун нь тодорхойгүй байхад юу.../минут дуусав./

**Ц.Даваасүрэн:** Хариулъя б. Наранцогт.

**С.Наранцогт:** Энэ хувь эзэмшил, үнэгүй эзэмших тухай заалт бүтээгдэхүүн борлуулах хоёр чинь тэс хоёр өөр зүйл. Яг тэр Ашигт малтмалын хууль, сүүлд Цөмийн энергийн хуульд орсон тэр бүтээгдэхүүнээр орлуулах гэдэг үг, үсэг ерөөсөө байхгүй. Тэр компанийн хувь эзэмшигчдийг үнэгүй эзэмших тухай л заалтууд байгаа шүү дээ гишүүн ээ. Тэр ТЭЗҮ-г одоо Уул уурхайн яам их дэлгэрэнгүй, яг тодорхой хариулж өгөх нь зүйтэй байна.

**Ц.Даваасүрэн:** 8. ТЭЗҮ-гүйгээр гишүүд ингээд та нарын ашигтай гээд байгааг бодитойгоор харах боломжгүй байна л гээд байгаа юм л даа.

**Г.Намчинсүрэн:** Аж үйлдвэрийн, эрдэс баялгийн яам Намчинсүрэн. Ганбаатар гишүүний асуултад хариулъя.

Энэ компани, “Бадрах Энержи” ХХК-ийн орд ажиллах ТЭЗҮ-ийн тодотголыг бол ШУТИС-ийн харьяа Уул уурхайн хүрээлэн боловсруулсан. Тэгээд ТЭЗҮ дээр нь холбогдох хууль тогтоомж, дүрэм, журмын хүрээнд шинжээч нар нь томилогдоод ажиллаад, шүүмж дүгнэлтээ өгөөд, эргээд хариу тайлбартайгаа танилцаад Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөл дээр хэлэлцээд явж байгаа юм. Түрүүн бас Учрал сайд хэлчихлээ. Энэ нөгөө төрийн эзэмшлийн 34 хувь нь өчигдрийн байдал хүртэл компани талтай байсан учраас эцэслэж болохгүй. Яагаад вэ гэхээр ТЭЗҮ-ийг хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хууль тогтоомжийн хүрээнд л боловсруулах үүрэгтэй.

Тэгэхээр тооцоолол бүгд бэлэн. Одоо бол ТЭЗҮ-ийг нь баталгаажуулаад цааш нь аваад явчихна.

**Ц.Даваасүрэн:** Тэгээд яах вэ, ер нь бол сая хуулиас авсан уу яасан Ашигт малтмалын хууль дээр чинь байсан шүү дээ. ТЭЗҮ баталж байж тэр төслийн үр өгөөжтэй эсэхийг нь мэдэрч байж хөрөнгө оруулалтын гэрээг батална гэдэг заалттай байсан байхгүй юу. Тэрийг л асуугаад байх шиг байгаа юм.

Ингээд Цогтбаатар гишүүн. Ахиад гүйцэд хариул. Үгүй бол 1 минут гэдгийгээ ав ав Ганбаатар гишүүн.

**С.Ганбаатар:** Би түрүүнээс хойш асуусан юман дээрээ яагаад гүйцэд хариулаагүй учраас гэдэг нь байна шүү дээ. Өгөөж гэдэг юмыг Оюу толгой дээр ч гэсэн ярьж байсан шүү. Бүр 54 хувь гэж байсан байх аа. Тэгээд өдөр болгон 1 сая доллар Монголд орж ирнэ. Монголын Засгийн газрын төсвийн гуравны нэгийн ачааллыг үүрнэ гэж зааж байсан. 10 мянган ажлын байр бий болгоно. Бүгд худлаа. Тэднүүсийг ярьж, бие биеэ долоож, улс төрчид долоож байсан болохоос биш цагаан дээр хараар ингэж бичээгүй. Тэгж хулхидуулсан. Одоо би цагаан дээр хараар бичсэн юмыг асуухлаар ямар ч бичигдээгүй юм хариулаад байгаа байхгүй юу. Миний асууж байгаа асуулт бол ерөөсөө л тэр худалдаж байгаа борлуулалтын 2 хувь, тэр 4 хувь зардлын хөрөнгө, хөрөнгийн 4 хувийг эднүүс ингээд авчихсан тохиолдолд манай ашиг гэдэг би үг хэлээд байгаа. Өгөөж яриагүй. Ашиг нөлөөлөх үү гэдэг л юм асуусан.

Хоёрдугаарт, эцэст нь нэг юм асуучихъя даа. Хөөш олон улсын бие даасан хөндлөнгийн шинжээч авсан уу? Нэр.../минут дуусав./

**Ц.Даваасүрэн:** Зөвлөх компани авсан юм уу? Хэн хариулах юм? 4 номер Жавхлан сайд.

**Б.Жавхлан:** Ганбаатар гишүүн ээ Оюутолгойн гэрээнээс хойш манай Ганбаатар гишүүн, Даваасүрэн дарга, манай Бат-Эрдэнэ гишүүн, Болорчулуун гишүүн гээд үнэхээр 10 гаруй жил бид дараагийн хөрөнгө оруулалтын гэрээгээ хэрхэн яаж Монголын талд илүү их ашигтай, үр өгөөжтэй хийх вэ гэдэг курст Монгол орон өөрсдөө суусан. Та бүхэнд бас баярлаж байгаа. Тэрний үр дүнд өнөөдрийн энэ гэрээ амжилттай болбол тэрний үр дүн гэж бас бид харж байгаа юм. Эндээс их бид нар сургамж авч үлдсэн. Та тэгэхээр надад итгэ энэ ноу хау төлбөр, маркетингийн төлбөр Монголын үр өгөөжид огт нөлөөлөхгүй. Энэ өсвөл манай өгөөж өснө, буурвал манай өгөөж буурна гэсэн ойлголт байхгүй. Бид нар 51 хувиа л барина. Дээрээс нь энэ маркетингийн фий гэж байгаа юм байна.../минут дуусав./

**Ц.Даваасүрэн:** 4 номерын микрофон.

**Б.Жавхлан:** Компанийн санхүүгийн тайланд энэ чинь арай өөрөөр тусгагдах байхгүй юу. Татварын зорилгоор хасагдах зардалд огт тооцогдохгүй. Энэ маань өөрөө цаанаа өөрөө 100 доллароор бид нар бүтээгдэхүүнээ борлууллаа гэхэд 2 доллар нь цаанаа үлдэх юм байгаа юм. Үүгээр тэр маркетингийнхаа зардлыг хийгээд явна гэсэн үг. Тийм учраас энэ бидэнд ерөөсөө огт нөлөө үзүүлэхгүй, дээрээс нь өмнөх гэрээнүүдээс хамаагүй өндөр үр өгөөжтэй байж чадахаар ийм гэрээ хийж, заалт орж, ингэж түгжээс хийж болж чадсан байгаа гэдгийг хариуцлагатай хэлье.

**Ц.Даваасүрэн:** Цогтбаатар гишүүн? Байхгүй байна. Булгантуяа гишүүн? Байхгүй байна. Гишүүд асуулт асууж дууслаа.

Үг хэлэх гишүүдийн нэрсийг авъя.

Ганбаатар гишүүнээр тасаллаа. Батжаргал гишүүн үгээ хэлье.

**Ж.Батжаргал:** Гэрээний төслийг муу тааруу болж энэ тэр гэж ярьж байгаа хүн нэг ч байхгүй. Өмнөх гэрээнүүдийг бодвол нэлээн тийм элэг гаргаж, үр өгөөж дээшлүүлсэн гэрээ болсон байна гэдэг талаасаа ярьж байгаа. Бүгд тэгж үзэж байгаа. Гагцхүү хуулиар тусгайлан зохицуулчихсан харилцаатай юмнуудыг бариулахгүй хийгээд байгаа юм биш биз дээ гэдэг юм л яригдаад байгаа. Үгүй ээ, хэдүүлээ байна шүү дээ Монголд ноогдож байгаа хувиа өөр төрлөөр орлуулж байгаа ухаантай юм бол тэр 24 хувийг үнэтэй хамааруулж зарим газар нь “тэг” болгодог зарим газар нь 5 хувь болгодог тийм юм байдаг юм уу? Тэгж болохгүй шүү дээ. Угаасаа бид ашгийн 24 хувийг хүртэх юмаа тусгай төлбөрөөр орлуулж байгаа бол 1 л хувь байх ёстой. Тэр дэлхийн зах зээл дээр тухайн бүтээгдэхүүний үнэ ямар байхаас үл хамаарч авах ёстой зүйл байхгүй юу. Тэгээд тийм юм оруулж ирчхээд өөдөөс их цэцэрхээд юм яриад байж болохгүй шүү дээ. Нэг.

Хоёрдугаарт, энэ гэрээн дээр чинь энгийн 34 хувийнхаа хувьцааг давуу эрхийн 10 болгоно гээд хэлчхээд байна. Наадах чинь бичвэр нь мөн юм уу? Энгийн 34 ы хувийн хувьцааны 10-ыг нь давуу эрхийн хувьцаанд шилжүүлээд, үлдсэнийг нь ашигт малтмалын нөөц ашигласны тусгай төлбөрөөр орлуулна гэж энэ гэрээндээ зааж өгөхгүй юм уу? Тэр үг чинь ерөөсөө хаа ч байхгүй байгаад байна шүү дээ. Үүнийгээ хэдүүлээ яаж зохицуулах ёстой юм? Би бол энэ гэрээг чинь уншихаар зэрэг өө өнөө энгийн 34 нь давуу эрхийн 10-аар дүйж байгаа юм байна гэдэг юм уншигдаад байна шүү дээ. Угаасаа гэрээн дээр чинь яг л тэгж уншигдаж байна. Та нар хар л даа тэр 7.1-ээ? Тэгж уншигдаад байгаа биз дээ? Тэгээд ийм ийм зүйлүүдээ анхаараад энэ гэрээгээ улам сайжруулах талын юмаа хиймээр байна. Тэр Их Хурлаар батлуулах гээд байгаа тэр Их Хурлын тогтоолын хавсралтыг хэлэлцүүлэг нь эцсийн шат руугаа орчихсон байх болохгүй л гэж ярих байлгүй. Засгийн газар татаж авч, буцааж оруулж ирэх хэрэгтэй. Тэнд бид орлуулах тухай юм ярьж байгаа учраас үнэтэй холбогдож зарим газраа 0 хувь байдаг юм, зарим газраа 5 хувь байдаг юм энэ тэр гэж ярьж болохгүй шүү дээ. 24 хувиа л хэдүүлээ АМНАТ-аар орлуулах гэж байгаа юм бол 1 л хувь байх ёстой ямар ч тохиолдолд.

**Ц.Даваасүрэн:** Ганбаатар гишүүн үг хэлье.

**С.Ганбаатар:** Энэ өнөөдөр ингээд хөрөнгө оруулалтын гэрээний төсөл дээр байгаа цагаан дээр хараар бичсэн зүйлүүдтэй холбогдуулж л би асууж байгаа. Санаанаасаа зохиож нэг ч юм ярихгүй байгаа. Харин хариултууд нь дандаа энэ цагаан дээр хараар бичсэн юман дээр байхгүй зүйлээр дандаа хариулж байгаа.

Тэгэхлээр хөрөнгө оруулагчийн тал хатуу анхаарах ёстой нэг зүйл гэвэл араас нь ард түмний, ард иргэдийн мандатыг аваад итгэлийг нь аваад хатуу нэхэл хатуутайгаар араас нь шаардаж, шахаж хариуцлага тооцно. Шаардлагатай бол Улсын Их Хурал буцаж татаж авч энэ дээр ярилцах тэр эрх нь байгаа гэдгийг гэрээ байгуулах гээд биднээс эрх авах гээд байж байгаа та нарт онцгой анхааруулж хэлье. Мэдээж олон сайн зүйлүүд байгаа. Тэрийг ярих цаг ч алга.

Жишээ нь, миний хамгийн их баярлаж байгаа зүйл гэвэл Оюу толгой дээр байгаа ТУЗ-д байгаа тэр 3 хүн амралтад явчихсан шүү дээ. Хөөрхий хэдэн сая

доллар ч билээ, хэдэн мянган доллар ч билээ аваад л амарч байгаа хэдэн улсууд. Энд 3 хүн биш 1 хүн байна. Чамлалтай юм шиг боловч БЭТ тавих эрхтэй. Шууд эсэргүүцэж ингэж зардал нэмээд биднүүсийн, 17.8 тэрбум долларын өрийг Оюу толгой тавьчихсан. Энэ өр тэгээд “Рио Тинто”-гийн өр гэж та нар бодож байна уу? Үгүй, Монголын говийн алт, зэсээр энэ өрийг барагдуулна. Монголчууд ингээд л тэнэгтээд л сууж байна. Цаадуул чинь тэнэгүүдийг сайхан малласан даа гэж боддог болохоос биш, хөөрхий надад ач буянаа хайрласан буянтай улсууд гэж хэзээ ч боддоггүй юм. Түүнтэй адилхан өнөөдөр ийм алдаа хийхгүйн төлөө хамт олон хичээсэн. Энийг бол хэлнэ. Учрал даргаар ахлуулаад хамт олон үнэхээр хичээсэн. Хэлэлцээр дээр улам нарийн, хатуу анхааралтай бид байна. Бүр нарийн шалгана.

Тэгээд урьд нь Оюутолгойн гэрээ байгуулсан хүмүүс өнөөдөр буруудаад байгаа нь бие даасан хөндлөнгийн шинжээчийн дүгнэлт гаргуулаагүй. Яг санхүүгийн модель, шинжээчийн дүгнэлтийг заавал гаргуулж байж. Улс төрчид өнөөдөр ураны мэргэжилтнүүд биш шүү дээ. Экспертүүд, шинжээчдийнхээ дүгнэлтийг тойрч та нар ярьж шийдвэр гаргавал 5 жилийн дараа, 10 жилийн дараа сайн, муугаа дуудуулахгүй.

Тэгэхлээр би асууж байгаа юм, нууц биш шүү дээ. Хэн зөвлөсөн юм бэ? Экспертүүд шинжээчдийн дүгнэлт, хөндлөнгийн гэж байгаа юм шүү дүгнэлт гаргасан нь хаа байна? Тэгээд ТЭЗҮ-г бид заавал үзэх ёстой. Та нар тэр технологи, тэр нууцын гарын үсгийг нь зуруулж байгаад ард түмний мандатыг авчихсан, ард иргэдийнхээ төлөөлж тэдний баялаг, хөрөнгийн талаар шийдвэр гаргах гэж байгаа биднээс предмет тэр судлагдахууныг нь нууна гэдэг чинь ямар аймшигтай юм хийж байна? Энэ бол татаа тунгаадуулж биднийг шийдвэр гаргуулж байгаа байхгүй юу. Яах вэ хүмүүс ингээд л Оюутолгойг ярьсны төлөө ингэ, үгүй шүү дээ Оюутолгойг ярьсны төлөө тэдний “Рио Тинто”-гоос мөнгө авсан хөлсний алуурчдад би 20 жил алуулж байгаа. Юуных нь одоо нэр хүнд байх вэ дээ. Нэр хүндгүй болтлоо хусуулдаг ажил шүү дээ энэ чинь.

Тэгэхлээр асууна энэ хөрөнгийн талаар. Баялгийн баялгийг ард түмэнд ашигтай байх талаар цаашид онцгой анхаарна ярьж байгаа. Та нарын энэ цагаан дээр хараар бичээгүй байгаа энэ олон зүйлийг чинь ТЭЗҮ дээрээс, гэрээний зүйл, заалт дээр нарийвчилж асууж харна. Өнөөдөр энэ протоколууд бүгд байгаа. Түүрүүн бараг усыг ерөөсөө, тэрийг Байгаль орчны байнгын хороон дээр би ярина. Тэгэхлээр найзууд минь ээ, 15 жилийн дараа адлуулаад алуулах гээд явж байгаа хүмүүс шиг болохгүйн тулд монголчуудын өмнө бид хариуцлагатайгаар энэ асуудалд ярина. 126 бол өөр хаа нэг газар 126 шиг ийм хүмүүс энэ дээр санаа зовоод явахгүй байгаа. Бид ёстой өөрсдийгөө зовтол нь унших ёстой, харах ёстой үг үсэггүй.

**Ц.Даваасүрэн:** Ганбаатар гишүүн үг хэлж дууслаа.

Ер нь бас ахиц дэвшил гарсан уу гэвэл гарсан юм байна Оюутолгойтой харьцуулахад. Тэгээд Ганбаатар гишүүн хэлж байна шүү дээ. Бид бол Оюутолгойн төлөө энэ гэрээг ашигтай байлгахын төлөө элдвээр хэлүүлээд л явж байгаа шүү дээ. Элдвээр хэлүүлээд явж байгаа. Хийгээгүй хулгайгаа хийсэн болгож бид нар явж байна, адгийн шаар болгож байна биднийг.

Тэгэхдээ өнөөдөр Оюутолгойгоос тодорхой үр дүн гараад л байгаа байхгүй юу. Бид нар хэлээгүй бол өнөөдрийн зүгээр л болж байгаа юм шиг л явах байсан.



Тэгэхээр энэ дээр бас Оюутолгойгоос сайжруулсан юмнууд бол байна. Сайд нар маань хүртэл бас ингээд Хэрэг эрхлэхийн дарга маань, Сангийн сайд маань Оюу толгой үр ашиггүй болсныг хүлээн зөвшөөрөөд байж байна шүү дээ. Энэ чинь сайн тал байхгүй юу. Засгийн газар бидэнтэй нэг талд ирсэн байна. Ямар ч гэсэн борлуулалтын орлогын 50 хувиа монголоороо дамжуулъя гэдэг сэтгэл гаргасан байна.

Нөгөө талаар өгөөжийн тохируулга хий гэж. Зөв. Одоо Оюу толгой дээр бид нар 54 хувийг авна гээд байгаа мөртөө авч чадахгүй л байгаа шүү дээ. Оюу толгой бол өр төлдөг компани болчихсон байгаа. Бид нар ирэх он жилүүдэд 60 тэрбум, 60 их наяд энэ чинь хүүгээрээ бүр өсөөд явна. 70, 80 их наяд болох байх. Ийм зээл л төлнө энэ компаниар. Зээл л төлнө. 38 хүртэл ямар ч ноогдол ашиг авахгүй. Тэгэхээр тэрнээс л тийм биш байгаасай гэж бид бодож байгаа шүү дээ. Тэр талаас нь бодож та бүгд бас тэр өгөөжийн тохируулга гэдэг юм оруулсан чинь сайн зүйл. Сайн зүйл.

Нөгөө тал нь бол бас зээлийг хязгаарлах гэж оролдож байгаа юм байна лээ. Зөв. Оюу толгой шиг ингэж зээл төлдөг компани болгохгүй гэж оролдсон байна лээ. Бас сайн юмыг нь бид нар хэлэх ёстой. Тэгээд тэрийгээ ТУЗ-ийн гишүүн нь хориг тавих эрхтэй юм байна лээ зээл дээр бол. Гэхдээ сайжруулах зүйл байна уу гэвэл байна. Оюутолгойгоос дордсон зүйл юу юм гэж? Менежментийн төлбөрөөс их хувь хүртэх гээд байгаа байхгүй юу тэд нар. Оюутолгойн менежментийн төлбөрийн 6 хувиа зардлаас авдаг. Энэ дээр маркетингийн төлбөр нэрээр борлуулалтын 2 хувь, ноу хау-ын төлбөр хэлбэрээр зардлаас 4 хувь, уже 6 хувь болчихож байна шүү дээ. Гэхдээ бүүр борлуулалтаас шүү.

Тийм учраас та бүхэн энийгээ бидтэй зөвшилцөж байна, Их Хуралтай зөвшилцөж байна гэж би ойлгож байна. Тийм учраас энийгээ дахин ярь. Дахин ярь. Энэ хувь байхгүй болчихвол бидний авах өгөөж л нэмэгдэнэ. Эд нарын авах хувь. Үгүй ээ тэд нар энэ ураныг авах гэж байгаа болохоос биш монголчууд бид нар энийг авъя, энийг бариад өгөөч гээгүй шүү дээ. Тэгээд Нигерээс хөөгдчихөөд л энэ ураныг авъя гээд байгаа шүү дээ. Үгүй тэд нар ямар нөү хау-гаараа авна уу, технологиороо авна уу тэр бидэнд ямар хамаатай юм, тэрний төлөө яагаад бид нар төлбөр төлөх ёстой юм? Утгагүй зүйл шүү дээ. Өөрсдөө авах гэж байж юун маркетингийн төлбөр. Энэ утгагүй зүйл шүү дээ.

Тэгэхээр ийм зүйлүүдийг хожим гаргуулахгүй байхын төлөө бас та хэд маань цаашдаа бас анхаараарай. Энэ дээр муухай юм ажиглагдаж байгаа нь байна шүү. Нөгөө зардлаа өсгөдөг хөшүүрэг байж байгаа байхгүй юу. Ноу хау-ныхаа төлбөрийг зардлаас тооцож авна гэж байгаа юм. Тийм л учраас бас энэ дутуугаа нөхсөн зарим зүйлийг энэ зөвшилцсөний дараа бас манай Учрал сайд, ажлын хэсгийнхэн бас анхаараарай. Гишүүдийн хэлээд байгаа зүйл, Батжаргал гишүүний тэр хэлсэн зүйл, тэр 24 хувиа бид нар нөөцийн төлбөр болгочоод энэ дээр чинь бас алдаа гараад байна шүү гээд байгаа энэ тэрийг бас анхаараарай гэдгийг бас хэлэх байна.

Хамгийн том давуу тал юу болсон гэвэл Үндсэн хуулийн 6.2-ын ард түмний хүртэх өгөөжийг энэ төслөөс 51 хувь байлгая гэдэг тохируулга оруулж байгаа нь хамгийн сайн зүйл.

Тэгэхдээ өгөөжөө яаж тооцох вэ гэдгийг бас анхаарах хэрэгтэй шүү. Ямар өгөөжийг эрээд байгаа юм гэж. Өгөөжгүй болтол зардлаа өсгөчих вий гэдгийг бас анхаараач гэдгийг хэлье.

Ингээд гишүүд үг хэлж дууслаа.

Монгол Улсын Засгийн газар болон Монгол, Францын хамтарсан “Бадрах Энержи” ХХК-ийн хөрөнгө оруулагч Орано Майнинг компани хооронд байгуулах хөрөнгө оруулалтын гэрээний төслийг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

16-аас 11 гишүүн дэмжиж, 68.8 хувиар гэрээний төслийг зөвшилцөхийг дэмжлээ.

Батжаргал гишүүнийг, Ганзориг гишүүнийг дэмжсэнээр протоколд авъя.

Хэлэлцэх асуудал дууслаа.

Өнөөдрийн энэ Монгол Улсын Засгийн газар болон Монгол, Францын хамтарсан “Бадрах Энержи” ХХК-ийн хөрөнгө оруулагч Орано Майнинг компанитай хооронд байгуулах хөрөнгө оруулалтын гэрээний төслийн хэлэлцүүлгийг явуулсан талаарх Төсвийн байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Тэмүүлэн гишүүн Аюулгүй байдлын байнгын хороонд танилцуулъя. Гадаад бодлогын аюулгүй байнгын хороонд Тэмүүлэн танилцуулна.

Монгол Улсын Засгийн газар хооронд Монгол Улсын Засгийн газар болон Монгол Францын хамтарсан “Бадрах Энержи” ХХК-ийн хөрөнгө оруулагч Орано Майнинг компани хооронд байгуулах хөрөнгө оруулалтын төслийн хэлэлцүүлгийг явуулж дууслаа.

Төсвийн байнгын хорооны өнөөдрийн хуралдаан хаасныг мэдэгдье. Баярлалаа гишүүд ээ.

14.25 цаг

*ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ  
ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ*

*Д.ОТГОНДЭЛГЭР*

